

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН ДОРНОГОВЬ  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН ХООРОНД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААР  
2025 ОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 12 дугаар сарын 08

Сайншанд хот

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2025 ОНЫ ТӨСӨВ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Хүрсэн түвшин	Үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9
3.1. Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.								
1	3.1.1.  Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулан, орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулах;	-	Угийг бичгийн хөтлөлтийн хувь	2018 оны судалгаагаар гарсан улсын дундаж үзүүлэлт	Угийг бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулсан байна. Угийг бичгийн хөтлөлтийн хувь нэмэгдсэн байна.	0,4%	Эцэг эх, өвөг дээдсийнхээ удмын мэдээллийг дэлгэрүүлэх, хадгалж хамгаалах, үр хойчдоо өвлүүлэн үлдээх зорилгоор Насан туршийн суралцахуйн төвийн 5 багш угийн бичгийн сургагч багшаар ажиллаж иргэдэд угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг түгээн дэлгэрүүлж байна.  Аймгийн Музей сургалт, судалгааны төвөөс “Соёлын өвийн цогц үйлчилгээг суманд” хөтөлбөрийн хүрээнд 4 удаагийн сургалтаар 132 иргэнд, 6 сумын Соёлын төв 14 удаагийн танхимын сургалтаар 252 иргэн, 246 хүүхдэд, Сайншанд сумын 7 багийн 120 ахмад настуудад 1 удаагийн танхимын сургалт, нийт 19 удаагийн сургалтад 750 иргэнийг хамруулан угсаа гарвал, овог төрлөө тэмдэглэн хадгалах чухал мэдлэг ойлголтыг олголоо.  Мөн аймгийн хэмжээнд 5 соёлын төв иргэдэд зориулан үзүүлэнгийн танхимдаа угийн бичиг хөтлөх ач холбогдол, хэрхэн хөтлөх тухай 21 төрлийн мэдээллийг байршуулж, 3 сумын Соёлын төв угийн бичиг хөтлөх арга зүйн гарын авлагыг 253, угийн бичгийн программ дээр ажиллах зааврыг 500 иргэнд тараан угийн бичиг хөтлөх ач холбогдлыг сурталчлан таниулж ажиллалаа.  Тайлант онд аймгийн хэмжээнд 21,801 өрх бүртгэлтэйгээс 2069 буюу 9,4% нь угийн бичиг хөтөлж хэвшсэн үзүүлэлттэй байна.	Хэрэгжсэн

								Өнгөрсөн онтой харьцуулахад угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо 0,4% буюу 9-өөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	
<b>3.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар:</b>									
2	3.1.2.1.	Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;	14,700.0	1. Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө-1	2024 онд гарсан гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн тоо	Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол, хэрэг, зөрчлийн тоо буурсан байна.	1	<p>Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2025 онд хэрэгжүүлэх 12 дэд бүлэг 51 заалт бүхий төлөвлөгөөг баталсан.</p> <p>Улирал тутам хуралдаж, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц болон аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл, шалтгаан нөхцөлийн талаар хэлэлцэж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажилласан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна.</p> <p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 702,3 сая төгрөгийн төсөв батлагдаж 11 сарын байдлаар 598,0 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, далд үйлдэгдэж буй хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нарын аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдсэн этгээдүүдийг дахин энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Амар тайван гэр бүл", "Хүчирхийллийг зогсооё", "Сум, багийн-Хяналт", "Эерэг хандлага-Зөв дадал" зэрэг нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулан үр дүнг тооцож ажиллалаа.</p> <p>Мөн насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчил, үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэх зорилгоор "Цахим орчны хэрэглээ", "Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх, аюулгүй байдал", "Өөрчлөлийг өөрөөсөө" сэдэвт сургалтыг ерөнхий боловсролын 22 сургуулийн 4500 сурагч, 1800 эцэг эх, асран хамгаалагч, Политехник коллежийн 550 оюутан, 56 багш, хамтарсан багийн 165 гишүүдэд, 975 иргэнийг тус тус хамруулан зохион байгуулсан.</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 20%, хүүхдийн эсрэг гэмт хэрэг 23.7%, насанд хүрээгүй хүний бэлгийн хүчирхийлэл 42%, насанд хүрээгүй хохирсон хүний тоо 15.4%, хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 68 хувиар тус тус буурсан үр дүнтэй байна.</p>	Хэрэгжсэн
				20%					

3	3.1. 2.2.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах.		1.Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2024 онд зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо	Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурсан байна.	37	<p>Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга" сургалтыг зохион байгуулж, 22 нийгмийн ажилтныг гэр бүлийн сургагч багшаар бэлтгэсэн бөгөөд 14 суманд 37 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 15,000 орчим эцэг эх, асран хамгаалагчийг хамруулан хүүхдийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн мэдлэгийг олголоо.</p> <p>Өнгөрсөн онтой харьцуулахад сургалт нөлөөллийн арга хэмжээний тоо 32,1% буюу 14-өөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p> <p>Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчил, үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэх зорилгоор "Цахим орчны хэрэглээ", "Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх, аюулгүй байдал", "Өөрчлөлийг өөрөөсөө" сэдэвт сургалтыг ерөнхий боловсролын 22 сургуулийн 4500 сурагч, 1800 эцэг эх, асран хамгаалагч, Политехник коллежийн 550 оюутан, 56 багш, хамтарсан багийн 165 гишүүд, 975 иргэнийг тус тус хамруулан зохион байгуулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд 27 хамтарсан баг гэрийн эргэлтийг долоо хоног бүр зохион байгуулж, эрсдэлт нөхцөлд байгаа 60 хүүхдийг илрүүлэн, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, хоол хүнсний дэмжлэг олгох, боловсролын үйлчилгээнд хамруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 20%, хүүхдийн эсрэг гэмт хэрэг 23.7%, насанд хүрээгүй хүний бэлгийн хүчирхийлэл 42%, насанд хүрээгүй хохирсон хүний тоо 15.4%, хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 68 хувиар тус тус буурсан үр дүнтэй байна.</p>	Хэрэгжсэн
				20%					
4	3.1. 2.3.	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох;	Орон нутгийн төсвийн хөрө	Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ авсан гэр бүлийн тоо	-	Гэр бүлд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсролын хүртээмж,	2883	<p>Гэр бүл, хүүхдийн сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тайлант хугацаанд ерөнхий боловсролын сургуулиудын 13, хүүхдийн цэцэрлэгийн 2, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2, нийт 17 сэтгэл зүйч сэтгэл зүйн зөвлөгөө, сургалтыг 2883 гэр бүлд, давхардсан тоогоор 12726 хүүхэдэд,</p>	Хэрэгжсэн

			нгөө р			чанар сайжирна.	<p>ганцаарчилсан зөвлөгөөг 996 багш, суралцагчид хүргэж, нийт давхардсан тоогоор 16605 хүнд үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>Өнгөрсөн онтой харьцуулахад сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдсан иргэд 26,4,-иар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар 2025 оны 09 дүгээр сараас мэргэжлийн 2 сэтгэл зүйчийг томилон ажиллуулж, 30 хүүхэд 7 эцэг эхэд ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүлсэн бөгөөд үйлчилгээний үр дүнд сэтгэл санааны тогтвортой байдлаа хадгалах, стресс дарамтыг даван туулах, бусадтай харилцах чадвараа сайжруулах чадварт суралцлаа.</p> <p>Мөн гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй, ар гэрийн анхаарал халамж сул 10-16 насны 30 хөвгүүдийг хамруулан англи хэл, сайн дурын ажил болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх "Боловсролоор үлгэрлэе" 100 хоногийн нөлөөллийн сургалтыг зохион байгууллаа.</p> <p>Аймгийн ерөнхий боловсролын 13 сургууль, хүүхдийн 2 цэцэрлэг, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар мэргэжлийн сэтгэл зүйчээр хангагдсан нь өмнөх онтой харьцуулахад 10 буюу 58,8%-иар сэтгэл зүйчийн тоог нэмэгдүүлэн ажиллалаа.</p>		
5	3.1. 2.4.	Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах;		1.Батлагдсан төсөв-100%	2024 онд баталсан төсөв.	Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний зардлыг 100% тусгаж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар	155,0 сая төгрөг	<p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/02 дугаар тогтоолоор гэр бүлийн хүчирхийллийн гэрч хохирогч хамгаалах, хүүхдийн хөгжил оролцооны зардалд 155,0 сая төгрөгийг баталсан.</p> <p>Нийт төсвийн 85,0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2025 оны А/51 дугаар захирамжаар "Жаргалан" хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны зардалд олгосон бөгөөд хүүхдийн зусланд 4 ээлжээр 713 хүүхдийг хүлээн авч хөгжлийн үйлчилгээнд хамруулсан.</p> <p>Аймгийн Засаг даргын 2025 оны А/52 дугаар захирамжаар Түр хамгаалах байрны үйл ажиллагааны зардалд 70.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.</p> <p>Түр хамгаалах байр тайлант хугацаанд 2 нийгмийн ажилтан, 1 сэтгэл зүйчийн орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж, 35 хүүхэд, 1</p>	Хэрэгжсэн
		2.Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-иас дээш түвшинд биелэх	97%						

						нэмэгдсэн байна.		иргэнийг 4-31 хүртэлх хоногоор хүлээн авч эрүүл мэнд, боловсрол, ахуйн болон нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлсэн. Жилийн эцсийн байдлаар батлагдсан төсвийн 119,9 сая төгрөгийг зарцуулж, үйл ажиллагааны хэрэгжилт 97% байна.	
<b>3.1.3. Хүүхдийн эрхийн талаар:</b>									
6	3.1. 3.1.	Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө хэрэгжүүлэх; эрх, батлан	1,597,5 88.3	1.Төлөвлөгөө баталсан эсэх	-	Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна.	3	Орон нутгийн хүүхэд хөгжил, хамгааллын тогтолцоонд оролцогч талуудын үүрэг хариуцлага, чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн бодлогын баримт бичигтэй уялдуулан баталсан. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2025 онд хэрэгжүүлэх 12 дэд бүлэг 51 заалт бүхий төлөвлөгөөг батлан, улирал тутам хуралдан төлөвлөгөөний хэрэгжилтийн явц болон аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл, шалтгаан нөхцөлийн талаар хэлэлцэж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажилласан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна.	Хэрэгжсэн
				2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь			92,6 %	Хүүхдийн төлөө зөвлөлийн төлөвлөгөөг 5 зорилт, 17 арга хэмжээтэй төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийн явцыг улирал тутам тайлагнасан, төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо 2025 онд 4 зорилт, 13 арга хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилт 98 хувьтай байна. Мөн салбар дундын уялдаа холбоо, үр нөлөөг сайжруулах ажлын хүрээнд "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга", "Асран хамгаалагчийн үүрэг оролцоо", "Хамтын шийдэл-Үр дүнд суурилсан хариу үйлчилгээ" сэдэвт чадавхжуулах сургалтыг тус тус зохион байгуулж нийт 27 хамтарсан багийн 165 гишүүнийг хамруулан аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын 2025 оны А/79 дүгээр тушаалаар 10,8 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Холбогдох салбар зөвлөлийн төлөвлөгөөг хяналтад авч, салбар хоорондын харилцаа	

							холбоог сайжруулан, хөгжил оролцоо, хүмүүжил төлөвшлийн арга хэмжээг хамтран зохион байгуулж хэвшсэн. Нийт төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 92,6% байна.	
7	3.1. 3.2.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх;	Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь	2024 онд хамрагдсан хүүхдийн тоо	Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 25 хувиар өссөн байна.	35,3 %	Хүүхдийн ордныг "Хүүхэд хөгжлийн төв" болгон хүүхдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчныг бүрдүүлсэн. "Хүүхэд хөгжлийн төв"-д хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хөгжил, оролцоог нэмэгдүүлэх спорт болон соёл урлагийн нийт 19 дугуйлан, 31 холбоод үйл ажиллагаа явуулж, 1691 хүүхдийг хамруулан хөгжил, оролцоог нэмэгдүүлж байна. Мөн ерөнхий боловсролын 22 сургуульд спортын 92, урлагийн 61, судлагдахууны 176, бусад 109 сонгон секц, дугуйланг 30 суралцагч, 28 сайн дурын ажилтан, 343 багш удирдан чиглүүлсэн ба давхардсан тоогоор 7905 суралцагчийг хамруулсан. Хичээлээс гадуурх "2и төсөл", "Англи хэлтэй Дорноговь", "Төслийн цаг", "Брэнд төсөл" зэрэг 19 хөтөлбөрт 3904 суралцагч хамруулсан. Аймгийн хэмжээнд 27027 хүүхэд байгаагаас 9457 буюу 35,3% нь хөгжил, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээнд хамрагдсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 3,7%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	Хэрэгжсэн
8	3.1. 3.3.	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах;	Баталсан төсвийн хэмжээ	2024 онд баталсан төсөв	"Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна.	1,2 тэрбум	Аймгийн Засаг даргын 2023 оны А/764 дүгээр захирамжаар "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус орон нутгийн зөвлөл"-ийг байгуулсан. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/02 дугаар тогтоолоор бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор "Сүү", "Үдийн хоол", "Steam" хөтөлбөрүүдэд 1,2 тэрбум төгрөг батлан зарцуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийн үзүүлэлт, судалгааг үндэслэн суралцагчдын уураг, амин дэмийн хэрэглээг нэмэгдүүлэх, эрүүл аюулгүй, чанартай хоол хүнсээр хангах, суралцах анхаарал төвлөрлийг сайжруулж, сурлагын чанарт ахиц гаргах зорилгоор "Үдийн хоол" хөтөлбөрийг	Хэрэгжсэн

						<p>аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 21 сургуулийн 6-9 дүгээр ангийн нийт 5720 суралцагчийг хамруулан хэрэгжүүлсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын 2025 оны А/81 захирамжаар "Үдийн хоол" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвийн 926.6 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Аймгийн хэмжээний хүүхдийн хоолны зөвлөлийг Засаг даргын 2025 оны А/680 дугаар дугаар захирамжаар байгуулсан.</p> <p>Мөн аймгийн Засаг даргын 2025 оны А/79 захирамжийн дагуу "Сүү хөтөлбөр"-ийг орон нутгийн төсвийн 272,7 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр төрийн өмчийн 33 цэцэрлэгийн 4407 суралцагчийг өдөр бүр сүү хөтөлбөрт хамруулсан. "Сүү хөтөлбөр"-ийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд төрийн өмчийн 33 цэцэрлэгийн 3485 хүүхдийг биеийн өндөр, шүдний өвчлөл болон эрдсийн шинжилгээнд хамруулж, судалгааны үр дүнд тулгуурлан ажилласан.</p> <p>Хүүхдийн хөгжил, төлөвшил, эрүүл, мэнд, асаргаа халамж, хамгаалал, хооллолт 5 хөгжлийн чиглэлээр эцэг эх, асран хамгаалагч олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор "Мэдээллийн цаг-444" үйл ажиллагааг сургуулийн өмнөх боловсролд төрийн болон төрийн бус 15 байгууллагатай хамтран 68 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж, давхардсан тоогоор 620 албан хаагч, 2300 хүүхэд, 3950 эцэг эх, асран хамгаалагчийг хамрууллаа.</p>		
9	3.1. 3.4.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;	1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо	-	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна.	1	Тайлант оны жилийн эцсийн байдлаар Аж, ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлагчдыг алдаршуулах, соёлын өвийг хамгаалах, сэргээх, музей, номын сангийн үйл ажиллагаа болон хөгжим, кино, гар урлал, тайзны урлагийн бүтээл туурвих, тоглох, түгээх үйл ажиллагаанд 198,9 сая төгрөг, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд	Хэрэгжсэн

				2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая. төг/			877,3 сая төгрөг	<p>бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид 324,5 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас зарласан тэргүүлэх чиглэлээр гадаадын их, дээд сургууль, дотоодын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд суралцаж байгаа оюутан, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгосон сургалтын төлбөрийн тэтгэлэгт 241,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд 10 иргэнд эмчилгээний зардалд 42 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор 70,4 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус олгож, нийт 877,3 сая төгрөгийн дэмжлэг тусламжийг нийгмийн хариуцлагын хүрээнд олгож аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтын дагуу албан татвараас хасаж хөнгөлөлт үзүүлсэн.</p>	
10	3.1. 3.5.	Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах;	Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо	-	Хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа сайжирсан байна.	83	<p>Аймгийн хэмжээнд хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр Хүүхдийн зөвлөл, Өсвөрийн парламент, Лидер сурагч академи, Охидын зөвлөл, Эко клуб, Өсвөрийн сэтгэл зүйчид клуб зэрэг нийт 6 хүүхдийн оролцооны байгууллага тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд "Хүүхэд хөгжлийн төв"-д байр танхимаар ханган хамтран ажиллаж байна.</p> <p>Мөн ерөнхий боловсролын 22 сургуулийн хүүхдийн оролцооны 77 байгууллагыг танхимаар хангаж, 1657 суралцагчийг оролцооны байгууллагад хамруулсан.</p> <p>Хүүхдийн оролцооны байгууллагуудын санаачилгаар "Бүтээлч ирээдүйг хамтдаа бүтээнэ" уран илтгэлийн тэмцээн, "Хайраар дүүрэн захиа" шүлгийн тэмцээн болон дэлхийн "Сансрын 7 хоног", "Бид зорилготой охид" охидын өдөрлөг, "Өсвөрийн парламент", "Хүүхэд, хайр, ирээдүй" зэрэг арга хэмжээнд давхардсан тоогоор 4900 гаруй хүүхэд багачуудыг хамруулж, 23,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Хүүхдийн байгууллагын 10 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан хүүхдийн үндэсний чуулганд хүүхдийн зөвлөлийн 10 гишүүн хамрагдаж, шийдвэр гаргах түвшинд дуу хоолойгоо хүргэсэн. Мөн "Үндэсний майхант</p>	Хэрэгжсэн	

								цугларалт"-д хүүхдийн зөвлөлийн 7 гишүүн хамрагдаж, "Эко саван" төслийг танилцуулан Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас 3,0 сая төгрөгийн санхүүжилтийг авсан.	
11	3.1. 3.6.	"Олон нийтийн байцаагч"-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх.	-	1.Олон нийтийн байцаагчийн тоо	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 50 хувиар өссөн байна.	17	73,3 %	Аймгийн хэмжээнд олон нийтийн байцаагч ажиллах 33 орон тоо батлагдсанаас Цагдаагийн ерөнхий газарт 14 хоногийн сургалтад хамрагдаж, мэргэжлийн гэрчилгээтэй болсон 17 олон нийтийн байцаагч ажиллаж байна.	Хэрэгжсэн
				2.Илрүүлсэн хүүхдийн тоо				Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх зорилгоор хамтарсан багуудын гишүүдээс гэрийн эргэлтийг долоо хоног бүр зохион байгуулж, эрсдэлт нөхцөлд байгаа 60 хүүхдийг шинээр илрүүлж, 47 хүүхдийг сум, багийн хамтарсан багаар хэлэлцэн нөхөн сэргээх, хяналтад авах, хоол хүнсний дэмжлэг үзүүлэх, боловсролын үйлчилгээнд хамруулах арга хэмжээг авч хүнс тэжээл ахуйн хэрэглээний 10,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Сэтгэл зүйн үйлчилгээ шаардлагатай 26 хүүхдийг сэтгэл зүйн үйлчилгээнд холбон зуучилсан. Сум, баг бүрд хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтантай болсноор эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийг илрүүлэх, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж эрсдэлт нөхцөлд байгаа 796 хүүхдээс түр хамгаалах, нөхөн сэргээх, асрамж халамжийн төвд зуучлах замаар өндөр эрсдэлтэй хүүхдийг 27-өөр, бага эрсдэлтэй хүүхдийг 124-өөр бууруулж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо 645 болсон. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өнгөрсөн онд 16 байсан нь 44 буюу 73,3%-иар нэмэгдсэн. Аймгийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо 0,3 хувиар буурсан бөгөөд нийт хүүхдийн 2,5 хувийг эзэлж байна.	
<b>3.1.4. Хүүхэд хамгааллын талаар:</b>									
12	3.1. 4.1.	"Хүүхэд хамгааллын бодлого"-ыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх;	-	Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн	Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн	60		Аймгийн хэмжээнд эцэг эхийн зөвлөлтэй 152 байгууллагаас "Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг"-ийг шинээр 2 байгууллага боловсруулан батлуулж, өссөн дүнгээр нийт 60	Хэрэгжсэн

			406,81 2.8	байгууллагын тоо		хэвшлийн байгууллагын 80 хувьд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлсэн байна.		байгууллага хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигтэй болсон. Тайлант хугацаанд шинээр 8 эцэг эхийн зөвлөл нэмэгдэж, 5 байгууллага шинээр хүүхдийн өрөө засаж тохижуулснаар өссөн дүнгээр нийт 152 эцэг эхийн зөвлөл, 85 байгууллага хүүхдийн өрөөтэй болж ажилтан албан хаагчдын хүүхдүүдэд амрах, тоглох, гэрийн даалгавраа хийх, хөгжих ая тухтай орчныг бүрдүүлсэн. "Хүүхэд хамгааллын бодлого"-ыг хэрэгжүүлж ажиллах арга зүйн сургалтыг зохион байгуулж 13 байгууллагын 150 ажилтныг хамрууллаа. Мөн Хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хуулийг сурталчлан таниулах хүрээнд 10 удаагийн сургалт, арга хэмжээнд 469 иргэнийг хамруулан гэр бүл дэх хүүхэд хамгаалалд асран хамгаалагчийн хуулиар хүлээсэн үүрэг оролцоо болон хүүхдийн эрх, хамгааллын хууль эрх зүйн мэдлэг ойлголтыг дээшлүүллээ. Төрийн болон хувийн хэвшлийн 136 байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс хүүхдийн хөгжил оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон 12 төрлийн үйл ажиллагааг насны ангиллаар зохион байгуулж давхардсан тоогоор 17,000 гаруй хүүхдийг хамруулж хөгжил оролцоог нэмэгдүүллээ.	
13	3.1. 4.2.	Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөлд байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх;		Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо	-	Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрд кейс нээж, үйлчилгээг бүрэн хүргэсэн байна.	645	Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан Улаанбаатар хотын "Өнөр бүл" асрамжийн газарт 2 хүүхэд, "Манай гэр" асрамж газарт 1 хүүхдийг зуучилсан. Асрамжийн төвд зуучлагдсан 3 хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийсэн бөгөөд 1 хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэж, 2 хүүхэд асрамжийн төвд хүмүүжиж байна. Тайлант оны 1 дүгээр улиралд эрсдэлт нөхцөлд байгаа 796 хүүхдээс түр хамгаалах, нөхөн сэргээх, асрамж халамжийн төвд зуучлах замаар өндөр эрсдэлтэй хүүхдийг 27-өөр, бага эрсдэлтэй хүүхдийг 124-өөр бууруулж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо жилийн эцсийн байдлаар 645 болсон. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоог бууруулахаар өндөр эрсдэлтэй 80 хүүхэд,	Хэрэгжсэн

						<p>хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн 124 дуудлагын тохиолдол, нийт 188 хүүхдэд тус бүр кейс нээж, шийдвэрлэсэн.</p> <p>Салбар дундын уялдаа холбоо, үр нөлөөг сайжруулах зорилгоор "Асран хамгаалагчийн үүрэг оролцоо", "Хамтын шийдэл-Үр дүнд суурилсан хариу үйлчилгээ" сэдэвт чадавхжуулах сургалтыг тус тус зохион байгуулж нийт 27 хамтарсан багийн 165 гишүүнийг хамруулсан бөгөөд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх үеийн журам, арга зүйг бодит нөхцөлд хэрэгжүүлэх аргачлал эзэмшсэн.</p> <p>Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо 645 болсон нь өнгөрсөн онтой харьцуулахад 0,3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p>		
14	3.1. 4.3.	<p>Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх;</p>	<p>1. Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв;</p>	26.7 хувь	<p>Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэсэн байна.</p>	<p>-</p> <p>5,4%</p>	<p>Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо 2025 онд 4 зорилт, 13 арга хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилт 98 хувьтай байна.</p> <p>2025 оны байдлаар 15 хүүхэд хууль зүйн хорооны хяналтад бүртгэгдсэн. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 8 хүүхдэд сургалт хүмүүжлийн арга хэмжээг зохион байгуулж нас, сэтгэхүйн онцлог хүүхдийн тусгасан саналыг үндэслэн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж эцэг эх асран хамгаалагчтай нь хариуцлага, нууцын гэрээг хийж хамтарч ажилласан.</p> <p>Бэлгийн хүчирхийллийн 3 хүүхдийн кейс дээр ажиллаж, холбогдох зөвлөгөө, үйлчилгээг үзүүлсэн.</p> <p>Ар гэрийн анхаарал халамж сул, гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй 14-18 насны зорилтот бүлгийн 30 хөвгүүдэд "Боловсролоор үлгэрлэе" нөлөөллийн арга хэмжээг "Өгөх урлаг" ТББ-тай хамтран 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Англи хэл, Сэтгэл зүйн үйлчилгээ, Сайн дурын ажил гэсэн чиглэлээр зохион байгуулж тайлан болох төсөл дээр ажилласан 4 багшийн тэмдэглэл судалгаан дээр үндэслэн 100 ном хэвлүүлэн, нийт 1,7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн хамтарч ажилласан.</p> <p>Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ авах шаардлагатай Эрсдэлт бүлгийн хүүхдүүдэд дээрх сэтгэл зүйн болон сургалт,</p>	Хэрэгжсэн

							нөлөөллийн үйлчилгээ үзүүлснээр гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй нөхцөл байдлыг бууруулж, тэдний нийгэмд өөрийгөө илэрхийлэх боломжийг нэмэгдүүллээ.	
15	3.1. 4.4.	Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих;	1.Хяналт, шалгалтын тоо,		Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95 хувь хангагдсан байна.	15	Засгийн газрын 2025 оны “Хүүхдийн эрхийг хамгаалах зарим арга хэмжээний тухай” 41 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 8 төрлийн сургалт мэдээллийг зохион байгуулж 2 төрлийн видео, контент 5 төрлийн зурагт хуудас зөвлөмжийг нийт 15000 хүнд хүргэн, 85 шэйр 20,000 хандалт авсан. “Хутагтын хурд-2025” хаврын бүсийн хурдан морины уралдаан зохион байгуулагдан нийт 3 насны 130 орчим морь, давхардсан тоогоор 150 хүүхэд оролцсон. Мөн Үндэсний их баяр наадмын хүрээнд тус аймагт 14 сумын баяр наадам зохион байгуулагдаж нийт 2387 морь, 1174 хүүхэд уралдаанд оролцсон. Хурдан морины уралдаанд оролцсон нийт хүүхдээс 23 хүүхэд мориноос унаж, бэртэл гэмтэлгүй 9 хүүхэд, хөнгөн хэлбэрийн бэртэлтэй 14 хүүхэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж, уралдааны замд хоцорсон 120 хүүхдийг асран хамгаалагч, уяачдад нь хүлээлгэн өгсөн. Тайлант хугацаанд 15 удаагийн урьдчилсан хяналт шалгалтыг зохион байгуулж, 8-аас доош настай 5 хүүхэд, стандарт хувцас хэрэглэлийн шаардлага хангаагүй 53 хүүхэд, бичиг баримтын зөрчилтэй 25 хүүхдийг хяналт шалгалтын мөрөөр илрүүлж, 83 хүүхдийн эрхийн баталгааг хангаж, зөрчлийг арилгасан. Нийт уралдаанд оролцсон 1174 хүүхдээс 98,8 хувь буюу 1160 хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.	Хэрэгжсэн
			2.Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь			100%		
16	3.1. 4.5.	Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;	1.Үйлчилгээ авсан өрхийн тоо	MNS 6948:2021, Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал . Ерөнхий	Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна.	1170	Дорноговь аймгийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 09-ний А/613 дугаар Гамшгаас хамгаалах орон тооны бус алба, тусгай зориулалттай мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах тухай захирамжийн дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын орон нутгийн албаны бүрэлдэхүүнийг томилсон. Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах 2 зорилт, 14 арга хэмжээ бүхий төлөвлөгөө,	Хэрэгжсэн
			хүүхдийн тоо			1885 2		

				зарчим, салбар дундын хамтын ажиллагаа ны нийтлэг шаардлага		<p>гамшгийн хор уршгийг арилгах 5 нөхцөл байдлын тус бүр 80 арга хэмжээ төлөвлөгөөг боловсруулан аймгийн Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтнээр хянуулж, 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хөдөлмөр, нийгмийн хамгааллын орон нутгийн албаны дарга баталсан.</p> <p>Монгол улсын Шадар сайдын баталсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан Гамшгаас хамгаалах команд штабын бэлтгэл сургуулилтад Гамшгийн үеийн онцгой нөхцөлд авах арга хэмжээ, урьдчилан сэргийлэх сургалт, зарлан мэдээллийн дохиогоор ажиллуулж, гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг шалгах үзлэг, сургуулилтад хамрагдсан.</p> <p>Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, гамшгийн үеийн бэлэн байдал, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 21 сургуульд орчны аюулгүй байдлыг бууруулах 43 сургалт зохион байгуулж, 562 багш, 11848 суралцагч, 1593 эцэг эх асран хамгаалагчийг хамруулсан.</p> <p>Гамшгийн үеийн бэлэн байдал, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1170 өрх, 18852 хүүхдийг хамруулан, нийт 119 арга хэмжээ зохион байгуулсан.</p>		
17	3.1. 4.6.	Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх;	Осол гэмтлийн буурсан хувь	-	Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна.	7,7%	<p>"Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх" арга хэмжээг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, аймгийн Цагдаагийн газартай хамтран Сайншанд сумын 8 багийн эрсдэлтэй газар нутаг, тоглоомын талбай орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчмын 60 байр талбайд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, нийт 30 гаруй зөрчлийг илрүүлж, шаардлагатай засвар үйлчилгээний зөвлөмжийг Сайншанд сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Уг зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай байна.</p> <p>Жилийн эцсийн байдлаар 0–15 насны хүүхдийн осол гэмтлийн 264 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 22 тохиолдлоор буюу 7.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p>	Хэрэгжсэн

18	3.1. 4.7.	Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах.		Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь	-	Хүүхдийн эрх зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг хаах, хязгаарлах арга хэмжээ авч, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулсан байна.	92,5 %	<p>Дорноговь аймгийн Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 04 дүгээр сарын 08- ны өдрийн А/07 дугаар захирамжаар баталсан “Шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, сүм хийдэд хамтарсан хяналт, шалгалт хийх удирдамж”-ийн хүрээнд Сайншанд суманд үйл ажиллагаа явуулж буй буддизмын 2, христос шашны 4, нийт 6 байгууллагад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.</p> <p>Хяналт шалгалтын хүрээнд боловсролын үйлчилгээнд хамрагдаагүй 1 хүүхэд, сүмийн үйл ажиллагаанд оролцогч хүүхдийн дэлгэрэнгүй бүртгэл, судалгааг ил задгай байрлуулсан нь хувь хүний нууцын баталгаа хангагдаагүй хүүхэд, гэр бүлийн хувийн нууцлал алдагдах эрсдэлтэй зэрэг зөрчлүүд илэрсэн.</p> <p>Хамтарсан хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулахаар шашны 4 байгууллагад зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт 85 хувьтай байна.</p> <p>Мөн Сайншанд суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа 8 худалдааны төвийн 30 үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид хүнсний аюулгүй байдлын хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг 100% шийдвэрлэж ажилласан.</p>	Хэрэгжсэн
3.2. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.									
3.2.1. Хөдөлмөрийн харилцааны талаар									
19	3.2. 1.1	Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах.	2,531,947.7	Хамрагдсан салбар, ААНБ-ын тоо	Улсын хэмжээнд 2024 онд 17 салбарын 400 иргэн хамрагдсан	ААНБ, иргэд олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилт сайжирсан байна.	306 ажил олгогч	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, сурталчлан таниулах зорилгоор 5 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, 124 аж ахуйн нэгж байгууллага, 659 ажилтан албан хаагч, 594 иргэнийг хамруулсан.</p> <p>Мөн “Хуульчийн зөвлөгөө, Хөдөлмөрийн тухай хууль” видео контентыг бэлтгэн цахим хуудсаар дамжуулан 6693 иргэнд зөвлөгөө, мэдээллийг хүргэж, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлээ.</p> <p>Салбар дундын уялдаа, хамтын ажиллагааг хангах зорилгоор “Хан баян” ажил олгогч эздийн холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулан хөдөлмөр эрхлэлтийн</p>	Хэрэгжсэн

							<p>үйлчилгээ, хөдөлмөрийн тухай хуулийн сургалтыг 14 суманд зохион байгуулж, 182 аж ахуйн нэгж байгууллага, 598 ажилтан албан хаагчийг хамруулан хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг сурталчлан таниулах 27 удаагийн сургалт, арга хэмжээнд 306 ажил олгогч, 1851 иргэн, ажилтан албан хаагчийг хамруулж хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлээ.</p>	
20	3.2.1.2	<p>Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих /хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр/-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.</p>	Хамрагдсан ААНБ-ын тоо,	-	<p>Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт сайжирч, хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлсэн байна</p>	13 байгууллага	<p>Тайлант оны жилийн эцсийн байдлаар “Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр”-т хамрагдах хүсэлтийг авч Сайншанд сумын “Дэлгэр баясах зам” ХХК, Замын-Үүд сумын “Өлгий Эргэл” ХХК, Хатанбулаг суманд тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг “Ийт гоби нетровк” ХХК-уудад хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомжтой уялдуулан ажил олгогчийн заавал тогтоох хөдөлмөрийн дотоод хэм, хэмжээ тэдгээртэй холбогдох 8 төрлийн баримт бичиг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлогын хэрэгжилтийн 1 баримт бичгийг боловсруулан тухайн байгууллагуудад хүлээлгэн өгсөн.</p> <p>Тайлант хугацаанд 3 удаагийн сургалтаар 13 байгууллагын 121 ажилтан албан хаагчдад хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн гэрээний талаар сургалт, арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.</p>	Хэрэгжсэн
			Зохион байгуулсан сургалтын тоо			3		
21	3.2.1.3	<p>Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх</p>	Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргааны тоо	Аймгийн хэмжээнд 2024 онд гарсан хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн	<p>Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж маргааны тоог бууруулсан байна.</p>	15	<p>Жилийн эцсийн байдлаар аймгийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах 3 талт хороонд нийт 15 өргөдөл, гомдол ирсэн.</p> <p>Хорооны хэлэлцэх асуудлын хүрээнд хамаарахгүй 1 өргөдлийг гомдол гаргагчид буцаасан нийт гомдлыг агуулгаар задалбал ёс зүй, зан харилцаанаас үүдсэн гомдол 1, цалин хөлстэй холбоотой 6, ажлаас үндэслэлгүй халагдсан 5, сахилгын шийтгэл буруу оногдуулсан 2 байна.</p> <p>Шийдвэрийн хэрэгжилтийн хувьд ажилд нь эргүүлэн авсан 1, цалин урамшуулал, нөхөн</p>	Хэрэгжсэн

					маргааны тоо			<p>төлбөр 2,6 сая төгрөгийг 1 гомдол гаргагчид олгуулсан. Талууд харилцан тохиролцсон 7, харилцан тохироогүй дараагийн шатанд буюу хуулийн байгууллагад шилжүүлсэн 5 гомдол байна.</p> <p>Аймгийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах 3 талт хороо хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор 17 байгууллагын 150 албан хаагчийг хамруулан хөдөлмөрийн харилцааны зөвлөгөө мэдээллийг хүргэн ажиллалаа.</p>		
22	3.2.1.4	Аймаг, сумын хамтын хэлэлцээрийн байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачилгатай ажиллах.		Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо	Аймгийн хэмжээнд 2024 онд бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо	Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж, бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн байна.	1 хэлэлцээр, 20 хамтын гэрээ	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу аймгийн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороог аймгийн Засаг даргын 2024 оны А/908 дугаар захирамжаар шинэчлэн байгуулж, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр 6 зорилт 65 арга хэмжээ бүхий хэлэлцээрийг баталсан.</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу “Дорноговь аймгийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2025-2027 оны хэлэлцээр” болон 20 байгууллагын хамтын гэрээг хуулийн үндэслэл шаардлагад нийцэж буй эсэхэд хяналт тавьж, мэдээллийн сан үүсгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Боловсрол, соёлын байгууллага -11</li> <li>- Эрүүл мэндийн байгууллага -5</li> <li>- Төрийн захиргааны байгууллага -2</li> <li>- Төрийн үйлчилгээ-1</li> <li>- Орон нутгийн өмчит ААНБ-1</li> </ul> <p>Мөн 4 байгууллага хамтын гэрээндээ нэмэлт өөрчлөлт оруулсан байна.</p> <p>Дорноговь аймгийн хэмжээнд хамтын гэрээ байгуулсан 60 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хамтын гэрээтэй холбоотой өргөдөл, гомдол ирээгүй байна.</p>	Хэрэгжсэн	
<b>3.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар:</b>										
23	3.2.2.1	2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн	1,399,839.7	Бодлогын баримт бичгийн тоо	Бүсчилсэн хөгжлийн бодлого	Судалгаа шинжилгээний ажлыг хийж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааны саналыг	1	Аймагт хэрэгжүүлж байгаа томоохон төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтын захиалгат ажил үйлчилгээг орон нутгийн бизнес эрхлэгчдээр гүйцэтгүүлэх бодлогыг хүрээнд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 15/06 дугаар тогтоолоор батлагдсан “Түншлэл ба хөгжил” аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтот хөтөлбөрийн хүрээнд 18 иргэн, 8 аж ахуйн нэгжид	Хэрэгжсэн	
				Судалгаа мэдээллийн тоо	Засгийн газрын үйл ажиллагаа		1			

		судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах.			ны 2024-2028 оны хөтөлбөр	боловсруулсан байна.	<p>нийт 1,956 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, 76 хувь нь төслийн үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж, 24 хувь нь техник тоног төхөөрөмж татан авах, ажлын байр барих, түүхий эд бэлтгэх зэргээр төслийн суурь нөхцөлийг бүрдүүлэх шатандаа ажиллаж байна.</p> <p>Мөн аймгийн хэмжээнд их дээд сургуульд суралцаж буй 1282 оюутны судалгаа мэдээллийг гаргаж, орон нутагт эрэлт хэрэгцээтэй малын эмч, уул уурхайн инженер, газар зохион байгуулалтын инженер, барилгын инженер, байгаль орчны мэргэжилтэн, эмч, багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг тэтгэлэгт хөтөлбөрүүдэд зуучлан ажиллалаа.</p> <p>Орон нутагт нэн шаардлагатай боловсон хүчин бэлтгэх "Гүүр" хөтөлбөрийн хүрээнд Солонгос улсын Чонжу их сургуультай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд бизнесийн удирдлага, архитектур мэргэжлээр суралцах 6 төгсөгчийг их сургуулийн хэлний бэлтгэлд хамруулсан.</p> <p>Дорноговь аймгаас их дээд сургуульд суралцаж байгаа 4 төгсөгчийг "Дэлгэр говийн хүн" сан төрийн бус байгууллагатай хамтран сургалтын төлбөрийн 100%-ийн тэтгэлэгт хамруулсан.</p> <p>Анагаах ухааны сургуулийн захирлын нэрэмжит тэтгэлэгт 5, аймаг, сум орон нутаг, хувийн аж ахуй нэгж байгууллагын дэмжлэгээр 32 оюутанд сургалтын төлбөрийн 45,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Тайлант оны байдлаар ерөнхийлөгчийн тэтгэлэгт 6, гадаадын тэтгэлэгт 33, дотоодын тэтгэлэгт 42 суралцагч буюу нийт 81 төгсөгч сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамруулсан нь өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 10%-иар өссөн.</p> <p>2025-2027 оны хугацаанд үүссэн сул чөлөөтэй ажлын байрны судалгаа, мэдээллийг 14 сум, ААНБ-уудаас нэгтгэсэн. Аймгийн хэмжээнд нийт 326 сул чөлөөтэй ажлын байрны мэдээллээр мэдээллийн сан үүсгэн ажиллалаа.</p>	
--	--	---	--	--	---------------------------	----------------------	--	--

24	3.2.2.2	Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож, хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах.		Судалгаа, мэдээллийн тоо	Албан ёсны статистик /Ажиллах хүчний судалгаа/  Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгэний мэдээллийн сан /EJOB систем/	Аймгийн / сум тус бүрээрх/ ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн сан үүссэн байна.	1	<p>Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болох хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцэн ажиллах боловсон хүчнийг сургаж, бэлтгэн ажлын байраар хангах цогц бодлогыг хэрэгжүүлэхээр тайлант хугацаанд ажлын байрны захиалга 1777, ажил хайгч иргэн 1365, шинэ ажлын байр 1125 бүртгэгдэж, 1121 иргэнийг ажилд зуучилж ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд хөдөө аж ахуй 173, уул уурхай 509, боловсруулах үйлдвэр 244, барилга 154, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа 135, боловсрол 200, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа 120, бусад 242, нийт 1777 ажлын байрны захиалгыг эдийн засгийн ангиллаар нарийвчлан судалгаа боловсруулан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж байна.</p> <p>2025-2027 онуудад бий болсон сул чөлөөтэй ажлын байрны судалгаа, мэдээллийг 14 сум, ААНБ-уудаас гаргуулан авснаар 14 сумын 207, 18 байгууллагын 119 сул чөлөөтэй ажлын байрны мэдээллээр мэдээллийн сан үүсгэсэн.</p>	Хэрэгжсэн
25	3.2.2.3	Орон нутгийн хүн амын бүлгүүд /эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг/-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.		1.Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь	Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын үзүүлэлтийн гүйцэтгэл  2023 он-ажиллах хүчний оролцооны түвшин улсын хэмжээнд 59,5%, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 56.3%,	Хүн амын бүлэг тус бүрээр судалгаа хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсч, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Ажиллах хүчний оролцооны түвшин улсын түвшингээс 1 нэгжээр их, хөдөлмөр эрхлэлтийн түвшин	<p>Тайлант хугацаанд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор ажилгүй, ажилгүйдэлд өртөж болзошгүй, ажил олоход хүндрэлтэй 1688 иргэний судалгааг гаргасан бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэгийн хэрэгцээнд тулгуурлан 1068 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, 180 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл, 52 иргэнд цогц үнэлгээг хийсэн.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгцээний судалгааг 14 сумаар гарган нэгтгэсэн бөгөөд судалгаанд 1688 иргэн хамрагдсанаас ажилгүй 1426, ажилгүйдэлд өртөж болзошгүй 119 иргэн, ажил олоход хүндрэлтэй 143 байна. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 155 иргэн байна. Насны ангиллаар авч үзвэл 18-34 насны 681, 35-54 насны 876, 55 ба түүнээс дээш насны 131 иргэн судалгаанд хамрагдсан.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний 01 дүгээр тогтоолоор "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p>	Хэрэгжсэн

				<p>ажилгүйдлийн түвшин 5.3%</p> <p>2022 он-ядуурлын түвшин хөдөө 35.6%, аймгийн төв 26.1%, сумын төв 30.6%, хөдөө нутаг 41.2%</p>		<p>ин 1,5 нэгжээр их, ажилгүйдлийн түвшин 0,8 нэгжээр бага байна а.</p> <p>(хөтөлбөр)-ны санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 39 ахмадыг хамруулан 35 байнгын ажлын байр, 7 түр ажлын байр, залуучуудын 2 багийг хамруулан байнгын 2, түр ажлын байр 2, 76 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулан 17 байнгын ажлын байр бий болгож, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн.</p> <p>Мөн "Түншлэл ба хөгжил" аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтот хөтөлбөрийн хүрээнд 18 иргэн, 8 аж ахуйн нэгжид нийт 1,956 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг орон нутгийн төсвөөс олгосон.</p> <p>Тайлант оны 3 дугаар улирлын байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин улсын түвшингээс 1 нэгжээр их, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 1,5 нэгжээр их, ажилгүйдлийн түвшин 0,8 нэгжээр бага байна.</p> <p>Өмнөх оны мөн үетэй харьцуулбал ажилгүйдлийн түвшин 0.1-ээр буурсан үзүүлэлттэй байна.</p>		
			<p>2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь</p>					
			<p>3.Аймгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө, гүйцэтгэлийн өсөлтийн хувь</p>			1,956 сая		
26	3.2.2.4	<p>Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол,</p>	<p>1.Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо</p>	<p>2023 он ДНБ-д нийгмийн тусламжийн зардлын эзлэх</p>	<p>Аймгийн хэмжээнд халамжаас хөдөлмөрт шилжих бодлого</p>	170	<p>Шинээр өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан 401.2-с доош оноотой 14 сумын 1095 зорилтот өрхийг хөгжүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2 зорилт, 8 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.</p>	Хэрэгжсэн

		санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах.	2.Холбогдох арга хэмжээний тоо	хувийн жин 3.7%, /2023 он/	бодитой хэрэгжиж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна.	8	<p>Сонгогдсон 1095 өрхөд 0-18 хүртэлх насны хүүхэд 2377, 18-с дээш насны 2061 иргэн байгаагаас ажил хөдөлмөр эрхэлдэг 1455, ажилгүй 606 иргэн байна.</p> <p>Ажилгүй 606 иргэнээс ахмад настан 121, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 154, оюутан 159, хөдөлмөр эрхлэх чадвартай боловч хөдөлмөр эрхлэхгүй байгаа 172 иргэн байна.</p> <p>Ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа 172 иргэнийг хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээнд давхардсан тоогоор 446 иргэнийг хамруулсан.</p> <p>Тайлант онд нийт 151 иргэнийг халамжаас хөдөлмөрт шилжүүлснээс 10 өрхийн 20 иргэнийг малжуулах арга хэмжээнд, байнгын ажлын байранд 60 иргэн, түр ажлын байранд 71 иргэнийг тус тус хамрууллаа.</p> <p>Аймгийн хэмжээнд 14 сумаас 2 сумын 74 өрх хүнсний эрхийн бичигт хамрагдаж байна. Хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй 74 өрхийн ажил хөдөлмөр эрхэлдэггүй 46 иргэнээс байнгын ажлын байранд 6 иргэн, түр ажлын байранд 13 иргэнийг зуучиллаа.</p> <p>Мөн аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй гэрээлэн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах 4 төрлийн сургалтыг 50 иргэнд зохион байгуулсан бөгөөд өрхийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой 20 өрхөд 36,0 сая төгрөгийн тусламж, гэрээт байгууллагад 11,1 сая төгрөг, нийт 47,1 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс олголоо.</p>	
			3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ			47,1 сая		
27	3.2. 2.5	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв /job center/-ийг орон нутагт нээн	1.Ажилд зуучлуулсан иргэний тооны өсөлт	-	Аймгийн хэмжээнд албан бусаас албан	-	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний "Job center"-ийг "Дарь овооны эзэд" ТББ-ын дэргэдэх хөдөлмөрийн биржтэй хамтран хэрэгжүүлэхээр	Хэрэгжээгүй

		ажиллуулах, дэмжлэг үзүүлэх.		2.Холбогдох арга хэмжээний тоо	хөдөлмөрт шилжин ажиллагсдын тоо нэмэгдсэн байна.	1	<p>өрөө тасалгааг стандартын дагуу бүрэн тохижуулсан.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвийн талаар туршлага судлах, үйл ажиллагаатай танилцах зорилгоор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 14 мэргэжилтэн Баянгол дүүргийн job center төвийн үйл ажиллагаатай танилцсан.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний "Job center"-ийн бэлтгэл ажлыг бүрэн хангасан.</p>	
28	3.2. 2.6	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих.	1.Хяналт шалгалтын тоо	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 30.9 мянга /2024 оны 4 улирал/	Аймгийн хэмжээнд цалин хөлстэй ажил эрхлэгч болон албан хөдөлмөр эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна.	1	<p>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг сумдад ажиллан нийт 8 сумын 2022-2024 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 62 иргэний үйл ажиллагаа, ажлын байр, эргэн төлөлтөд хяналт шалгалт хийж, үйл ажиллагааг тогтворжуулах, эргэн төлөлтийг гэрээний дагуу төвлөрүүлж ажиллах үүрэг чиглэлийг өгсөн.</p> <p>Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 2017-2023 онд хамрагдсан 119 ахмад, 2015-2024 онд хамрагдсан 421 иргэн, 2017-2024 онд хамрагдсан 41 залуучууд, 2020-2024 онд хамрагдсан 73 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мөшгөх судалгааг зохион байгуулж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа 283, нас барсан 16, эрүүл мэндийн улмаас үйл ажиллагаагаа эрхлэх боломжгүй болсон 6, шилжсэн болон ажилд орсон 23, ХХК болж өргөжсөн 1, үйл ажиллагаа зогссон 264, хаяг дээрээ байхгүй болон холбогдож чадаагүй 61 иргэний мэдээллийг шинэчилсэн.</p> <p>Мөн 2014-2024 онд малжуулах арга хэмжээнд хамрагдсан 421 малчин өрхөөс аймгийн аварга малчин 1, сумын аварга малчин 17, мянгат малчин 5 бий болсон байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)"-ны хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Тогтоолын дагуу шаардлага хангасан 88 иргэн, 1 хоршоо, 40 өрхөд, нийт 1162.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 168</p>	Хэрэгжсэн
			2.Судалгаа мэдээллийн тоо			1		
			3.Холбогдох арга хэмжээний тоо			1		

							байнгын, 17 түр ажлын байрыг бий болгосон болон хадгалсан байна. Төрийн албаны тухай хууль болон Захиргааны ерөнхий хууль, Засгийн газрын 2025 оны "Төрд учирсан хохирлыг барагдуулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай" 17 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж 2014-2024 онд санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн гэрээний үүргийн биелэлтэд хяналт шалгалтыг зохион байгуулж хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 48 иргэний 123.9 сая төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулсан.	
29	3.2. 2.7	Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инновац шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх.	1.Холбогдох арга хэмжээний тоо	2023 онд ХЭДС-аас шилдэг старт-ап залуучуудад олгох санхүүгийн дэмжлэгт 139 хүнийг хамруулж, 721.0 сая төгрөг зарцуулсан	Аймгийн хэмжээн өндөр технологийн, бүтээмжтэй ажлын байрны тоо, аж ахуй эрхлэгч нэмэгдсэн байна.	2	Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инновац шингэсэн шинэлэг санал санаачилгыг шалгаруулах говийн бүсийн START-UP хурдасгуур үйлчилгээнд эрүүл хооллолт чиглэлээр 1 баг хамрагдсан.	Хэрэгжсэн
			2.Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо			14	Аймгийн хэмжээний шилдэг гарааны бизнес эрхлэгч залуучуудын "Старт-ап" арга хэмжээнд 9 баг бүртгүүлж, 3 баг сургалт, хурдасгуур арга хэмжээнд хамрагдсанаас сонгон шалгаруулалтад 2 баг шалгарч 36 сарын хугацаатай, 50%-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй 15,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон.	
			3.Төлөвлөсөн зарцуулсан хөрөнгийн тоо			38,0	Арга хэмжээг Улаанбаатар хотын "Мэргэшсэн мэргэжил сургалтын төв" ТББ-тай хамтран зохион байгуулж, 8.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.	
			4.Шинээр бүртгүүлсэн патент /шинэ бүтээл, ашигтай загвар/-н тоо			-	Шинэлэг санал санаачилгыг дэмжиж гарааны бизнес эрхлэгч залуучуудад бизнес санааг сурталчлан таниулах, зөвлөгөө мэдээлэл хүргэх зорилгоор 2024 онд санхүүгийн дэмжлэг авсан "Little paws" жижиг амьтны эмнэлгийн үйл ажиллагааны богино бичлэг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан залуу үйлдвэрлэгч "Содон бургер" цехийн үүсгэн байгуулагчтай ярилцлага хийж тус тус цахим хуудсаар дамжуулж, 6105 гаруй хүний хандалт авсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 5 иргэнийг Улаанбаатар хотод зохион байгуулсан "Нутгийн брэнд" бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд зориулсан 3 хоногийн вакум сургалтад хамруулсан.	

							Орон нутгийн түүхий эдийн нөөц, боломж, онцлог давуу тал дээр тулгуурлан, өвөрмөц орц найрлага, хийц загвар бүхий орон нутгийн онцлогтой, газар зүйн заалттай брэнд бүтээгдэхүүнийг нээн илрүүлэх, дотооддоо төдийгүй олон улсад өрсөлдөх стандарт хангасан бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилгоор Брэнд бүтээгдэхүүн шалгаруулах удирдамжийн дагуу ажлын хэсэг байгуулан нийт 22 өрхийн болон жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн танилцуулга, материалыг үндэслэн сонгон шалгаруулалтыг явуулж Бүсийн брэнд бүтээгдэхүүнд өрсөлдөх 5 брэнд бүтээгдэхүүнийг шалгаруулав.	
30	3.2. 2.8	ХЭДС-аас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах.	1. Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо	2023 онд ХЭДС-аас борлуулалтын дэмжлэгт 460 хүн хамрагдаж 341,3 сая төгрөг зарцуулсан.	ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн ААН-ийн борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ төрөлжийн нэмэгдэж, хамрагдагсдын тоо, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн байна.	115	Орон нутгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах зорилгоор “Цагаан сар-2025”, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Тэнгэрийн хутагт” фестиваль зэрэг бүсийн болон орон нутгийн томоохон 7 арга хэмжээг зохион байгуулсан.  Нийт арга хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, худалдан борлуулах зорилгоор 115 иргэний бараа бүтээгдэхүүнийг 36,3 сая төгрөгөөр борлуулсан.	Хэрэгжсэн
			2. Төлөвлөсөн зарцуулсан хөрөнгийн тоо			36,6 сая		
31	3.2. 2.9	Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах.	Холбогдох арга хэмжээний тоо	2023 онд ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжихэд	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа өргөжиж, нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг нэмэгдсэн байна.	24	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар зөвлөл тайлант онд хуралдаж “Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл”-ийн 2024 оны ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хэлэлцэж, 2025 оны ажлын төлөвлөгөөг баталсан.  Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)”-г 7 үйлчилгээний 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд үүнээс орон нутагт хэрэгжих боломжтой 24 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн.	Хэрэгжсэн

				160,7 сая төгрөг зарцуулсан.			<p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа" -ны мэдээллийг тус үйл ажиллагаа (хөтөлбөр)-ны нээлт болон сар бүрийн Халамжаас-хөдөлмөрт 222 арга хэмжээгээр нийт 1798 иргэнд хүргэн ажилласан.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийг чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 322,0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалаар хангасан.</p> <p>Тайлант оны 11 дүгээр сарын байдлаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа арга хэмжээнд 733 иргэнийг хамруулж, 1,315.3 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 188 иргэн, хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаанд 395, түр ажлын байраар хангах арга хэмжээнд 150 иргэн хамрагдаж 168 иргэнийг байнгын, 167 иргэнийг түр ажлын байртай буюу нийт 335 ажлын байр бий болгосон.</p>	
32	3.2. 2.10	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах.</p>	1.Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ	<p>2023 онд ХЭДС-нд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ажлын байрны төлбөрөөс 6.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн.</p>	<p>Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэлт нэмэгдэж хөгжлийн бэрхшээлтэй хүн ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.</p>	168,4 сая	<p>Тайлант оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дэх заалтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Нийгмийн даатгалын газраас зохион байгуулсан "Даатгуулагчдын нэгдсэн зөвлөгөөн"-д оролцогч 362 ажил олгогч, иргэдэд дээрх хуулийн заалтын талаар мэдээлэл зөвлөгөө мэдээллийг хүргэсэн.</p> <p>Хуулийн хэрэгжилтийг сайжруулахаар 25 буюу түүнээс дээш ажилтантай байгууллагын судалгааг нарийвчлан боловсруулсан бөгөөд аймгийн хэмжээнд 25 буюу түүнээс дээш ажилтантай 143 аж ахуйн нэгж байгууллагад 311 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 25 буюу түүнээс доош ажилтантай 182 аж ахуйн нэгж байгууллагад 108 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, нийт 325 аж ахуйн нэгж байгууллагад 419 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна.</p> <p>Аймгийн хэмжээнд 50 буюу түүнээс дээш ажилтантай 70 аж ахуйн нэгж байгууллагад 395 ахмад ажиллаж байгаа бөгөөд 50 буюу түүнээс доош ажилтантай 196 байгууллагад 363 ахмад</p>	Хэрэгжсэн
			2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ			1,315.3 сая		
			3. Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо			36		

							<p>настан, нийт 266 аж ахуйн нэгж байгууллагат 758 ахмад настан ажиллаж байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 11 дүгээр сарын байдлаар Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүйн төлбөр 13 байгууллагаас 168.4 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.</p> <p>Тайлант онд хөгжлийн бэрхшээлтэй 36 иргэнийг ажлын байранд зуучилсан нь өмнөх онтой харьцуулбал 20 иргэнээр буюу 55.6%-аар өссөн байна.</p> <p>Өмнөх оны мөн үетэй харьцуулбал хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр төвлөрүүлсэн байгууллагын тоо 3-аар нэмэгдэж, төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн хэмжээ 2.3 сая төгрөгөөр буурсан байна.</p> <p>Тайлант оны 11 дүгээр сарын байдлаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа арга хэмжээнд 733 иргэнийг хамруулж, 1,315.3 сая төгрөгийг зарцууллаа.</p>	
<b>3.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар:</b>								
33	3.2. 3.1	<p>Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн зарцуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.</p>	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан эсэх	2024 оны хэрэгжилт	100	<p>Хөдөлмөр нийгмийн 3 талт оролцоонд тулгуурлан аймгийн Засаг даргын 2025 оны А/49 дүгээр захирамжаар ХАБЭА-н зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, 2 зорилт 18 арга хэмжээ бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан.</p> <p>Тайлант онд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог сайжруулах зорилгоор 10 сумын ХАБЭА-н салбар зөвлөлийн 21 гишүүнийг хамруулан арга зүйн зөвлөгөө өгч мэдлэг чадварыг дээшлүүллээ.</p> <p>Мөн ХАБЭА-н хууль тогтоомжийг сурталчлан таниулах сургалтыг 14 суманд зохион байгуулж, 182 ААНБ-ын 598 албан хаагчдыг хамруулсан. ХАБЭА-н сарын аяныг зохион байгуулж 16 ААНБ-ын хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас хэрэгсэл, тоног төхөөрөмж, мэргэжлийн багаж хэрэгслийг үзэсгэлэн хэлбэрээр 378 иргэдэд танилцуулж, сайн туршлагыг түгээлээ.</p> <p>Тайлант хугацаанд 24 үйл ажиллагаа зохион байгуулж, 210 аж ахуй нэгж байгууллага, 1353 иргэнийг хамруулан 9,8 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна.</p>	Хэрэгжсэн

								Жилийн эцсийн байдлаар 4 салбарын 32 ААНБ-т үзлэг шалгалтыг зохион байгуулж, 8 удаагийн уулзалт, арга хэмжээнд 356 иргэд, ажилтан албан хаагчийг хамруулан ХАБЭА-н тухай хуулийг сурталчлан таниуллаа. Мөн Барилгын үйлдвэрлэл эрхлэгч 47 аж ахуйн нэгж, байгууллага, бичил уурхай эрхлэгч 30 нөхөрлөлд болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаарх улсын байцаагчийн 11 заалт бүхий 2 зөвлөмжийг гарган нийт 77 ААНБ-д хүргүүлж, болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан.	
34	3.2. 3.2	Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай хортой, хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Төлөвлөсөн төсөв	2024 оны гүйцэтгэл	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	10,2 сая	Хөдөлмөр нийгмийн 3 талт оролцоонд тулгуурлан аймгийн Засаг даргын 2025 оны А/49 дүгээр захирамжаар ХАБЭА-н зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, 2 зорилт 18 арга хэмжээ бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан. Тайлант онд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог сайжруулах зорилгоор 10 сумын ХАБЭА-н салбар зөвлөлийн 21 гишүүнийг хамруулан арга зүйн зөвлөгөө өгч мэдлэг чадварыг дээшлүүлээ. Мөн ХАБЭА-н хууль тогтоомжийг сурталчлан таниулах сургалтыг 14 суманд зохион байгуулж, 182 ААНБ-ын 598 албан хаагчдыг хамруулсан. ХАБЭА-н сарын аяныг зохион байгуулж 16 ААНБ-ын хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас хэрэгсэл, тоног төхөөрөмж, мэргэжлийн багаж хэрэгслийг үзэсгэлэн хэлбэрээр 378 иргэдэд танилцуулж, сайн туршлагыг түгээлээ. Жилийн эцсийн байдлаар 4 салбарын 32 ААНБ-т үзлэг шалгалтыг зохион байгуулж, 8 удаагийн уулзалт, арга хэмжээнд 356 иргэд, ажилтан албан хаагчийг хамруулан ХАБЭА-н тухай хуулийг сурталчлан таниуллаа. Тайлант хугацаанд 24 үйл ажиллагаа зохион байгуулж, 210 аж ахуй нэгж байгууллага, 1353 иргэнийг хамруулан 9,8 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна.	Хэрэгжсэн
				2.Зохион байгуулсан арга хэмжээний тоо			24		

35	3.2. 3.3	Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг авран хамгаалахад чиглэгдсэн шуурхай арга хэмжээг авах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Төлөвлөсөн төсөв	2024 оны гүйцэтгэл	Тухай бүр арга хэмжээ авсан байх.	-	Тайлант хугацаанд хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчид аж ахуйн нэгж байгууллагын "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс"-оос судлан бүртгэж ирүүлсэн нийт 26 үйлдвэрлэлийн ослын актыг судлан үзэж хянан баталгаажуулж, /inspection.hudulmur-halamj.gov.mn/ цахим системд бүртгэж оруулсан. Нийт ослоос үхэлд хүргээгүй 21, үхэлд хүргэсэн 5 осол бүртгэгдсэн. Тайлант хугацаанд хурц хордлого гараагүй, үйлдвэрлэлийн ослын акттай санал нийлээгүй тохиолдол байхгүй тул улсын байцаагчийн дүгнэлт гараагүй байна. Өмнөх онд 33 ослын тоо бүртгэгдсэнээс үйлдвэрлэлийн ослын тоо 26 хувиар буурсан байна.	Хэрэгжсэн
				2.Тухай бүр авсан арга хэмжээний тоо			26		
<b>3.2.4. Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний талаар</b>									
36	3.2. 4.1	Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дадлагажуулан сургах, ажлын байраар хангах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо	2024.12.15 байдлаар:  Орон нутагт хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 8.1 мянган хүн	Аймгийн хэмжээнд ажилгүйдэл буурч хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	110	Дорноговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус 19 удаагийн хяналт шалгалтаар ажиллахдаа давхардсан тоогоор 137 аж ахуй нэгж байгууллагад хяналт шалгалтыг хийхэд 11 улсын 1676 гадаадын иргэн хамрагдсан. "Доншен газрын тос" ХХК-д 110 иргэн ажиллаж байгаагаас 14 иргэнийг, "Хөх бишрэлт" ХХК-д 78 иргэн ажиллаж байгаагаас 10 иргэнийг, "Эм Ти Эс Эйч Майнинг" ХХК -д 166 иргэн ажиллаж байгаагаас 2 иргэнийг ажлын байраар хангаж дагалдуулан сургаж байна.	Хэрэгжсэн
				2.Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ					
37	3.2. 4.2	Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид зөвлөгөө өгөх, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	2.Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ	8.1 мянган хүн	Хуулийн хэрэгжилт сайжирсан байна.	-	Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын А/403 дугаар захирамжийн дагуу 3 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, 10 аж ахуй нэгж, байгууллагыг хамруулан удирдлага, хүний нөөцийн мэргэжилтэнд "Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль"-ийн талаар мэдээлэл өгсөн. Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхэлж байгаа 9 улсын 3983 гадаадын иргэн бүртгэлтэй байна.	Хэрэгжсэн
				3.Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын монгол,			Монгол ажилтан		

				Н монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт			68,9 % Гадаад ажилтан 31%		
3.3. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.									
3.3.1. Нийгмийн даатгалын талаар:									
38	3.3.1.1.	Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран зохион байгуулах;	1,770,542.8	Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь	Улсын хэмжээнд сайн дураар даатгуулагчийн тоо 2023 он-152 800	Сайн дураар даатгуулагчийн тоог 10-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна.	3307	Тайлант оны жилийн эцсийн байдлаар сайн дурын даатгуулагчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалын шинэчлэгдсэн хууль тогтоомжийн дагуу ажил олгогч, албан байгууллага, оюутан, малчид, иргэдэд нийт 123 удаагийн сургалт, зөвлөгөөн, мэдээлэл хүргэх арга хэмжээг зохион байгуулж 5707 иргэнийг хамруулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/10 дугаар тушаалаар сайн дурын даатгуулагчийн тоог 3711-д хүргэхээр төлөвлөгөөг баталж гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан бөгөөд малчин 450, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх, эцэг 20, 0-3 настай хүүхэдтэй эх 114, ажилгүй иргэн 350, нийт 934 иргэнийг шинээр сайн дурын даатгалд хамруулсан. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах иргэдийн тоо 3307 болж буурсан бөгөөд ажилд орсон, нас барсан, тэтгэвэрт тогтоолгосон гэх үндэслэлээр нийт 865 иргэн сайн дурын даатгалын гэрээгээ цуцалсан үзүүлэлттэй байна. Аймгийн 25236 иргэн нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгэгдсэн бөгөөд өмнөх онтой сайн дурын даатгуулагчийн тоо 3,9 хувиар нэмэгдсэн.	Хэрэгжсэн
39	3.3.1.2.	Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;		Цахим хэлбэрт шилжүүлсэн тэтгэврийн хувийн	-	Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын	100%	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санхүүжилтээр тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулах программыг 10.0 сая төгрөгөөр худалдан авсан бөгөөд аймгийн хэмжээнд тэтгэвэр авч буй 10868 иргэний тэтгэврийн хувийн хэргийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн.	Хэрэгжсэн

				хэргийн эзлэх хувь		хувийн хэргийг 100% цахим хэлбэрт шилжүүлсэн байна.			
40	3.3. 1.3.	<p>Даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд ажил олгогч хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх, өр үүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулахад Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;</p>		Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо	Улсын хэмжээнд өртэй төсөвт байгууллагын тоо - 848		78	<p>Нийгмийн даатгалын сангийн 11 дүгээр сарын байдлаар 78 төсөвт байгууллагаас төлөгдөх 1,230.2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага бүртгэгдсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын 2025 оны А/263 дугаар захирамжаар "Даатгуулагчдын нэгдсэн зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, 4,7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.</p> <p>Уг зөвлөгөөнд 362 ажил олгогчийг хамруулан нийгмийн даатгалын тухай хуулийг сурталчлан таниулж ажиллалаа.</p> <p>Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2025 оны А/244 тушаалаар 2025 оны 09 дүгээр сарын 15 наас 1 сарын хугацаанд итгэлцлийн аяныг зохион байгуулсан.</p> <p>Аяны хүрээнд 20 ажил олгогчтой гэрээ байгуулж 34.6 сая төгрөгийн тэтгэмж олгож, 3 ажил олгогчийн дансыг нээж, 36 ажил олгогчтой гэрээ байгуулж, 146 ажил олгогчоос 1,678.8 сая төгрөгийг тус тус барагдуулж ажилласан.</p>	Хэрэгжсэн
41	3.3. 1.4.	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах;</p>		Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо	Улсын хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо 102446	Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо 25 хувиар бууруулсан байна.	2172	<p>Аймгийн хэмжээний хөдөлмөрийн чадвар алдсан 2172 иргэдийн судалгааг сум тус бүрээр гаргаж, сэргээн засах эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үйлчилгээнд хамрагдсан иргэдийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэсэн.</p> <p>Жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон нийт 674 хүнийг сэргээн засах тусламж үйлчилгээнд хамруулж, 441 хүнийг хэвтүүлэн эмчилсэн.</p> <p>Аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх "Эрүүл мэндийн магадлалын зөвлөл" 39 удаа хуралдаж, 1097 иргэний асуудлыг хэлэлцэж, 144 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг цуцалж, шинээр тогтоож 260 иргэнийг тогтоож, 692 иргэнийг сунгасан бөгөөд аймгийн хэмжээнд 6 сараас дээш хугацаагаар сунгалтаа хийлгээгүй хөдөлмөрийн чадвар алдсан иргэнгүй болсон.</p>	Хэрэгжсэн

								<p>Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 630 иргэнийг сургалтад хамруулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>Тайлант оны 11 дүгээр сарын байдлаар хөдөлмөрийн чадвар алдсан 144 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцалж, 135 иргэн хөдөлмөрийн чадвар алдалт шинээр тогтоосон.</p> <p>Өнгөрсөн онтой харьцуулахад хөдөлмөрийн чадвар алдалт тогтоосон иргэдийн тоо 9 буюу 0.41 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p>		
42	3.3.1.5.	Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд хамтран ажиллах.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд хамтран ажиллах.	147	<p>Нийгмийн даатгалын ерөнхий хууль батлагдаж 2024 оны 01 дүгээр сараас хэрэгжиж эхэлснээр иргэн бүр тэтгэврийн мөнгөн хуримтлалтай болж, мөнгөжүүлж эхэлсэн бөгөөд иргэн бүр тэтгэврийн мөнгөн хуримтлал, мөнгөжүүлсэн орлогоо байнга хянах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах хуулийн зохицуулалт нь 2030 оноос хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, сурталчлах, орон нутгийн иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор "Малчдын зөвлөгөөн"-д 4521, "Даатгалтай ирээдүй" арга хэмжээнд 748 суралцагч, "Даатгуулагчдын зөвлөгөөн"-д 362 ажил олгогчийг хамруулсан.</p> <p>Тайлант оны хугацаанд 147 удаагийн сургалт, арга хэмжээгээр 8130 иргэнд мэдээлэл хүргэж ажилласан.</p> <p>Мөнгөжүүлсэн орлогын талаар судалгааг аймгаар гаргадаг болох талаар саналыг холбогдох газарт уламжилсан.</p>	Хэрэгжсэн		
<b>3.3.2. Нийгмийн халамжийн чиглэлээр</b>										
43	3.3.2.1	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны	Орон нутгийн төсвийн	Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үүнээс	2024	Нийгмийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэдийг	54 иргэн	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгж, төрийн бус байгууллага сонгон шалгаруулах тендерт "Насан туршийн суралцахуйн төв" шалгарч 49,2 сая төгрөгөөр гэрээ байгуулж, 4 төрлийн сургалтыг 50 иргэнд зохион байгуулсан	Хэрэгжсэн	



							<p>туршлага солилцох, иргэдэд зөвлөгөө өгөх, уулзалт, явуулын нээлттэй цуглааныг зохион байгуулж, уулзалтад 250 гаруй иргэд хамрагдсан.</p> <p>Аймгийн мэргэжилтний баг “Архины хор уршиг ба хэрэглээ” сэдвээр 3 удаагийн сургалтыг аж ахуй нэгж, албан байгууллагуудад явуулж 174 хүнийг хамруулсан.</p> <p>Архины хор хөнөөлийг сурталчлан таниулах видео, постер зэрэг 13 зөвлөмж мэдээллийг 20 эрүүл мэндийн байгууллагын нийгмийн сүлжээнд байршуулж 4520 хандалтыг авч иргэдийг мэдээллээр ханган ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд архины хамааралтай 12 иргэнийг ажил хөдөлмөрт зуучиллаа.</p>		
45	3.3. 2.3	<p>Нийгмийн ажилтнуудын бусад салбарын ажилтнуудтай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулах, чадавхжуулах сургалтад тогтмол хамруулах</p>	<p>Орон нутгийн төсвийн хөрөнгөөр</p>	<p>1.Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо</p>	-	<p>Нийгмийн ажилтнуудын мэдлэг чадвар сайжирсан байна.</p>	39	<p>Аймгийн хэмжээнд 14 сумын 22 нийгмийн ажилтныг чадавхжуулахаар нийгмийн халамжийн хууль тогтоомж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх үйлчилгээгээр нийт 8 удаагийн зөвлөмж чиглэл өгч арга зүйгээр хангаж ажилласан.</p> <p>Зөвлөмж чиглэлийн дагуу албан хаагчид мэдлэг чадвараа дээшлүүлж, иргэдэд үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж, үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн.</p> <p>Аймгийн Боловсролын газраас “Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, онол арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх” сургалтаар 22 нийгмийн ажилтанд сургуулийн орчин дахь хүүхэд хамгаалалд анхаарах асуудлаар хууль эрх зүйн зохицуулалттай холбоотой мэдээлэл өгч, цаашид хамтарч ажиллах санал солилцон тусгай хэрэгцээт хүүхдийн сурч хөгжих эрхийг хангахад идэвх санаачилгатай ажиллахыг зөвлөсөн.</p> <p>Шинээр томилогдсон хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг чиглүүлэх мэргэшүүлэх үндэсний сургалт Дундговь аймагт зохион байгуулагдаж, 22 нийгмийн ажилтныг хамруулсан.</p> <p>“Хүмүүжлийн зэрэг арга”, “Асран хамгаалагчийн үүрэг оролцоо”, “Хамтын шийдэл-Үр дүнд суурилсан хариу үйлчилгээ” сэдэвт чадавхжуулах сургалтыг тус тус зохион байгуулж нийт 27 хамтарсан багийн 165 гишүүнийг хамруулан аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын 2025 оны А/79 дүгээр тушаалаар 10,8 сая төгрөгийн санхүүжилтийг</p>	Хэрэгжсэн
				<p>2.Сургалтын тоо</p>			2		

							<p>шийдвэрлэсэн. Уг сургалтаар хамтарсан багийн гишүүд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх үеийн журам, арга зүй, байгууллагуудын уялдаа холбооны талаар мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлж, бодит нөхцөлд хэрэгжүүлэх аргачлал эзэмшсэн.</p> <p>Уг сургалтын үр дүнд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр аймгийн 14 суманд нийт 39 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 15,300 орчим эцэг эх, багш, сурган хүмүүжүүлэгч, асран хамгаалагчийг хамруулсан хүүхдийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлж, хүүхэд хүмүүжлийн эерэг хандлагыг төлөвшүүлсэн.</p>		
<b>3.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар:</b>									
46	3.3. 3.1	Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Сургалт	-	30-аас доошгүй	51	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх ойлголт, хандлагыг төлөвшүүлэх, нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах зорилгоор "Халамжаас хөдөлмөрт 222" арга хэмжээний хүрээнд байнгын асаргаатай хүүхдийн асран хамгаалагч болон хөгжлийн бэрхшээлтэй 192 иргэнд, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 157 хүүхдийн эцэг эхэд, "Монгол Солонгосын хамтарсан шим тэжээл судлалын төв"-тэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй 20 хүүхдийн эх эцэг, асран хамгаалагчдад, "Хамтдаа гоё" арга хэмжээнд 40 эцэг эхийг хамрууллаа.</p> <p>Мөн хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай хэвтрийн 12 хүүхдэд Австралийн ротари клуб, Хангай сайн дурын нийгэмлэг тэргэнцэр, аймгийн ХГБХХГ-тай хамтран байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй 131 хүүхдэд эрүүл мэнд, дархлаажуулалтын багцыг олголоо.</p> <p>"Эрхэм нандин сувд" ТББ-аас санаачлан зохион байгуулсан нарийн мэргэжлийн эмч нарын удаагийн нэгдсэн үзлэг оношилгоонд 25 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулан 4,5 сая төгрөгийг дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Тусгай хэрэгцээт иргэдэд соёлын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор "Соёлын үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байдлаар зохион байгуулах</p>	Хэрэгжсэн

								нь" гарын авлага, номыг соёлын салбарын 18 байгууллагад мөрдлөг болгон ажиллаж байна. Тайлант оны хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх ойлголт, хандлагыг төлөвшүүлэх 26 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 1343 иргэнийг, 25 удаагийн танхимын сургалтаар 154 байгууллагын, 1759 төрийн албан хаагчийг хамрууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сургалт нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо 22,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	
47	3.3. 3.2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;	Орон нутгийн төстийн хөрөнгөөр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	20	6	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулж, 3 суманд сонгуулийн хороог байгуулсан. Монгол улсын сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.4, 66 дугар зүйлийн 66.4 дэх заалтын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох эрхийн хүрээнд санал авах бүхээгийг сонгуулийн хороо бүрд байрлуулж, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагааг хуульд заасан хугацаанд нь 3 хэсэг дээр 3 саналын хайрцгаар нийт 9 хүн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтийн дагуу зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, эрхийг хангах хүрээнд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн тухай ойлголт, иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх, төлөөлөгчийн бүрэн эрх, сонгуулийн тогтолцоо, сонгуулийн тойрог, мандат, санал тэмдэглэх заавар, тэдгээрийн онцлог болон сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны талаар 6 удаагийн мэдээллээр 118 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, нийт 653 иргэнийг хамруулж мэдээлэл өгсөн.	Хэрэгжсэн
48	3.3. 3.3	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэн, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах	Орон нутгийн төсвийн	Зохион байгуулсан арга хэмжээний тоо				Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх зорилгоор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар болон Эрүүл мэндийн газар хамтран "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бэлгийн боловсрол олгох" сургагч багш бэлтгэх сургалтыг	Хэрэгжсэн

			хөрөнг өөр					<p>2 жил тутам зохион байгуулж 15 эмэгтэй сургагч багшийг бэлтгэн гэрчилгээ олгосон.</p> <p>Жилийн эцсийн байдлаар 150 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 3 удаагийн сургалт, мэдээлэл өгсөн.</p> <p>"Үе тэнгийн сургагч багш чадавхжуулах" сургалтад ЕБ-ын 5-н сургуулийн 35 хүүхдийг хамруулж, аймгийн хэмжээнд 192 үе тэнгийн сургагч багш бэлтгэн, сургуулийн орчинд 19 удаагийн өртөөчилсэн сургалт зохион байгуулж, 517 хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгосон. Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үзүүлэх, боловсрол олгох 2 кабинетаар 4135 хүүхэд үйлчлүүлж, 631 хүүхдэд өвчлөл илрүүлж, 89.5%-ийг эмчилж, эрүүлжүүлэлд өмнөх оноос 36.6%-иар нэмэгдсэн.</p> <p>Мөн анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаар дамжуулан "Шилжилтийн насны онцлог", Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Жирэмслэлтээс сэргийлэх арга, Гэр бүл төлөвлөлт сэдэвт сургалтыг 2 удаа зохион байгуулж 105 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эцэг эх, асран хамгаалагч нарт мэдээлэл өгч 10 төрлийн зөвлөмж гарын авлагыг 205 ширхгийг тараасан.</p> <p>Сайншанд, Замын-Үүд сумын төрөх тасаг, сумдын эрүүл мэндийн төвд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан 17 ширхэг олон үйлдэлт төрөх ороор хангасан бөгөөд өрх, сумын эрүүл мэндийн төвд хөгжлийн бэрхшээлтэй 6 эмэгтэй эсэн мэнд амаржсан.</p>	
49	3.3. 3.4	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх дэмжих төвийг байгуулах	Орон нутгийн төсвийн хөрөнг өөр	Дэмжих төв	-	1	1	<p>Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх "Эрүүлжин хөгжих төв"-ийн үйл ажиллагааг 2020 оноос эхлэн тогтмолжуулж байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих чиглэлээр ажиллаж байна.</p> <p>Төвийн үйл ажиллагаа, хүүхдийн хоол хүнс болон цалингийн зардалд орон нутгийн төсвөөс 2024 онд 125,0 сая төгрөг, 2025 онд 135,0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.</p> <p>Аймгийн хэмжээнд 316 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас 128 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж, ЕБС-д 89, СӨБ-д 39, насан туршийн суралцахуйн төвд 21,</p>	Хэрэгжсэн

							<p>эрүүлжин хөгжих төвд хамрагдаж байгаа 9 хүүхэд нь суралцахад хүндрэлтэй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна.</p> <p>Сургуульд хамрагдаж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүдэд сэргээн засах, өдөр өнжүүлэх үйлчилгээ үзүүлэх "Эрүүлжин хөгжих төв"-д хүнд хэлбэрийн эмгэгтэй 9 хүүхдийг асаргааны үйлчилгээнд, 48 хүүхдийг бариа заслын үйлчилгээнд тус тус хамруулж байна.</p> <p>"Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, асран хамгаалагчдад үйлчлэх төв"-ийг барихаар 2023 оноос санал санаачилгыг гаргаж, зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж нийт төсөвт өртөг 4,5 тэрбум төгрөгөөр Барилга хөгжлийн төвийн магадлалын дүгнэлтээр баталгаажсан бөгөөд улсын төсөвт тусгуулах саналыг хүргүүлсэн.</p>	
50	3.3. 3.5	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	2	<p>Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 22-ны А/194 дугаар захирамжаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.</p> <p>Жилийн эцсийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийн санаачилгаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, сэргээн засах зорилгоор Улаанбаатарт зохион байгуулдаг нарийн мэргэжлийн эмч нарын нэгдсэн үзлэг оношилгоонд аймгийн хөгжлийн бэрхшээлтэй 25 хүүхдийг хамруулахад 4,5 сая төгрөгийн дэмжлэг олгосон.</p> <p>Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, салбар дундын уялдааг хангах асуудлаар арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор Дундговь аймагт зохион байгуулагдсан "Ability expo-2025" бүсийн цогц арга хэмжээнд аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг хамруулж 0,6 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь тус комиссын үйл</p>	Хэрэгжсэн

							ажиллагааг хэвийн явуулах өрөө танхим орчин нөхцөлөөр бүрэн ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 5,1 сая төгрөгийг зарцуулсан.		
51	3.3. 3.6	Орон нутгийн гамшгаас хамгаалах онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	100	100%	Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах 2 зорилт, 14 арга хэмжээ бүхий төлөвлөгөө, гамшгийн хор уршгийг арилгах 5 нөхцөл байдлын тус бүр 80 арга хэмжээ төлөвлөгөөг боловсруулан аймгийн Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтнээр хянуулж, 2025.10.14-ний өдөр хөдөлмөр, нийгмийн хамгааллын орон нутгийн албаны дарга баталсан. Уг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хоргодох байрны хүртээмжийг 13 суманд тус бүр 5 хорогдох байр, аймгийн төвд 12 хорогдох байр, нийт 77 байрны нөөцийн судалгааг гаргасан. Монгол улсын Шадар сайдын баталсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан Гамшгаас хамгаалах команд штабын бэлтгэл сургуулилтад Гамшгийн үеийн онцгой нөхцөлд авах арга хэмжээ, урьдчилан сэргийлэх сургалт, зарлан мэдээллийн дохиогоор ажиллуулж, гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг шалгах үзлэг, сургуулилтад батлагдсан төлөвлөгөөний дагуу ажилласан. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, гамшгийн үеийн бэлэн байдал, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 21 сургуульд орчны аюулгүй байдлыг бууруулах 43 сургалт зохион байгуулж, 562 багш, 11848 суралцагч, 1593 эцэг эх асран хамгаалагчийг хамруулсан. Гамшгийн үеийн бэлэн байдал, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 55 байгууллагын 1170 албан хаагч, 18852 суралцагчдыг хамруулан, нийт 119 арга хэмжээ зохион байгуулсан.	Хэрэгжсэн

52	3.3. 3.7	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх</p>	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	5	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх ойлголт, хандлагыг төлөвшүүлэх, нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах чиглэлээр байнгын асаргаатай хүүхдийн асран хамгаалагч болон хөгжлийн бэрхшээлтэй 192 иргэнд, хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 157 хүүхдийн эцэг эхэд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон шинэчлэгдэн гарсан дүрэм журмыг танилцуулж, зөвлөгөө мэдээллээр хангасан.</p> <p>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй 131 хүүхэд эрүүл мэнд, дархлаажуулалтын багцыг олгож, "Монгол Солонгосын хамтарсан шим тэжээл судлалын төв"-тэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй 20 хүүхдийн эх эцэг, асран хамгаалагчдад "Эцэг эхийн хандлага өөрчлөх, хүүхдийн хоол зүй шим тэжээл"-ийн талаар сургалтыг зохион байгуулсан.</p> <p>"Эрхэм нандин сувд" ТББ-аас санаачлан зохион байгуулж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нарийн мэргэжлийн эмч нарын 6 дахь удаагийн нэгдсэн үзлэг оношилгоонд хөгжлийн бэрхшээлтэй 25 хүүхдийг эцэг эхийн, хамт хамруулж, нийт 4,5 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан.</p> <p>Дэлхийн аутизмын өдрийн хүрээнд СЭМҮТ-ийн хүүхдийн сэтгэцийн эмч тус аймгийн аутизмтай хүүхдийн 15 эцэг эхийг хамруулан "Аутизмтай хүүхэдтэй хэрхэн зөв харьцах талаар" сургалтыг зохион байгуулж зөвлөгөө мэдээлэл өгч, нээлттэй ярилцлага хийсэн.</p> <p>Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан "ХАМТДАА ГОЁ" үйл ажиллагааг Аймгийн ИТХ, Сайншанд сумын ИТХ-ын төлөөлөгчдийн санаачилгаар Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газар, Хүүхдийн ордон хамтран зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй 68 хүүхэд эцэг, эх асран хамгаалагчид хамрагдсан.</p> <p>Тайлант хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн 8 төрлийн</p>	Хэрэгжсэн
----	-------------	--	--------------------------------	--------------------------------------	---	---	---	-----------

								нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 616 эцэг, эх, асран хамгаалагчийг хамруулсан.	
53	3.3. 3.8	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Гэрээ байгуулан хамтран ажилласан ТББ-н тоо	-	3	1	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлыг Монголын хараагүйчүүдийн холбоотой хамтран танхимын сургалтыг 24 аж ахуйн нэгж байгууллагын 72 албан хаагч, хөгжлийн бэрхшээлтэй 70 иргэнийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн 144-р заалт, Засгийн газрын 2022 оны 253-р тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам"-ыг 11 аж ахуйн нэгж, байгууллагат танилцуулж, мэдээлэл хүргэж нийт 193 ажилтан албан хаагч хамрагдсан.</p> <p>Мөн Нийгмийн даатгалын газраас зохион байгуулсан "Даатгуулагчдын нэгдсэн зөвлөгөөн"-д оролцогч 362 ажил олгогч болон иргэдэд дээрх хуулийн заалтын талаар мэдээлэл хийсэн.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2025 оны 11 дүгээр сарын байдлаар Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүйн төлбөр 13 байгууллагаас 168.4 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.</p> <p>Өмнөх оны мөн үетэй харьцуулбал хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн хэмжээ 2.3 сая төгрөгөөр буурсан байна.</p>	Хэрэгжсэн
54	3.3. 3.9	Орон нутгийн цахим хуудас, телевиз, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хүртээмжтэй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудасны тоо	-	5	5	<p>Орон нутгийн DTV, DSB, Gobi.mn телевиз, сайттай 2025 оны 01 дүгээр сараас эхлэн хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулан орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг бэлтгэн тухай бүр олон нийтэд хүргэн ажиллаж байгаа бөгөөд мэдээллийг хадмал орчуулгатайгаар түгээж байна.</p> <p>Мөн Засаг даргын эрхлэх хүрээний 26 байгууллагын цахим хуудсаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар байгууллагын дотоод үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг тухай бүр хүргэн ажиллаж байна.</p>	Хэрэгжсэн

							<p>Тайлант хугацаанд нийт 872 төрлийн мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод байршуулж, 2,5 сая хандалт авсан байна.</p> <p>Вебсайт, цахим хуудас болон хэвлэл мэдээллийн сувгаар иргэдэд тогтмол мэдээлэл хүргэн ажиллалаа.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын вебсайтын хүртээмжийн нэмэгдүүлэх зорилгоор үнийн судалгааны ажлыг эхлүүлсэн.</p>		
55	3.3. 3.10	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, олон талт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай зардлыг шийдвэрлэх, салбар байгууллагуудын оролцоо хамтын ажиллагааг сайжруулах.</p>	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	90	91,2	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын 2025 оны А/164 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан бөгөөд 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилт 25 арга хэмжээтэйгээр боловсруулан баталсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 91,2 хувьтай байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын чиглэлээр зохион байгуулсан 5 арга хэмжээнд давхардсан тоогоор 1678 иргэн хамрагдсан.</p> <p>ХБХЭМБНХСК-ын комиссын хурлыг 2025оны байдлаар 14 удаа хуралдаж, 295 хүүхдийн асуудал шийдвэрлэснээс шинээр 52 хүүхэд тогтоогдож, сунгагдсан 238 үүнээс цуцлагдсан 5 байна.</p> <p>Эрүүл мэндийн сайд, Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/68, А/62 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд өвчин гэмтлийн жагсаалт шалгуурын дагуу байнгын асаргааны 30 хувийн нэмэгдэлд хамрагдах хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 157 хүүхдийг дахин магадлах хурлыг 2 удаа зохион байгуулж шалгуурын дагуу 157 хүүхдийн асуудлыг хэлэлцэн 121 хүүхдэд байнгын асаргааны 30 хувийн нэмэгдлийг олгох шийдвэрийг гарган, 2025 оны 5 дугаар сарын олголтоор тэтгэмжийн зөрүүг олгосон.</p> <p>"Хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх 9,18,36 сартай хүүхдийн эрүүл мэнд хөгжлийн цогц үзлэг"-ийг тогтмолжуулж, давхардсан тоогоор 955 хүүхдийн 843(88.3%) нь үзлэгт хамрагдаж эмийн эмчилгээ, хооллолтын</p>	Хэрэгжсэн

								зөвлөгөөг өгсөн нь өмнөх оноос 12.3%-иар нэмэгдсэн.	
56	3.3. 3.11	Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна байгууламжийн дотор талын хүртээмжийг сайжруулах	Орон нутгийн төсөв	Хүртээмжтэй болгосон байгууллагын тоо	-	3	80	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах зорилгоор төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна, байгууламжийн дотор талын хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан. Тайлант хугацаанд Даланжаргалан, Мандах, Хатанбулаг, Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг буюу нийт 8 байгууллагын ариун цэврийн өрөөг засварлан орчин үеийн стандартад нийцсэн, тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөөг хүлээж авсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш, хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг албан байгууллагад мөрдүүлэх зорилгоор үзлэг шалгалт зохион байгуулж, 25 ба түүнээс дээш ажиллагсадтай 55 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан бөгөөд нийт 5049 ажилтан ажиллаж байгаагаас 163 хөгжлийн бэрхшээлтэй иргэн 1,7 сая төгрөгийн дундаж цалин хөлстэй ажиллаж байна.	Хэрэгжсэн
				Үүнээс:эхний ээлжинд НДГ, ХХУГ, ХГБХХГ, Нэг цэгийн үйлчилгээний төв			3	Ажлын байрандаа налуу замтай 23 аж ахуйн нэгж, тусгайлан ариун цэврийн өрөө шийдвэрлэсэн 9 аж ахуйн нэгж, стандартын шаардлага хангасан хаалгатай 24 аж ахуйн нэгж, зориулалтын машины зогсоолтой 14 аж ахуйн нэгж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэгш хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд олон нийт, орон сууцны барилгын 37 архитектур төлөвлөлтийн даалгаварт тусган ажлын болон загвар зургийг хянан баталсан. Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй 80 байгууллага байгаа бөгөөд өмнөх оноос 6,2 хувиар нэмэгдлээ.	
57	3.3. 3.12	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах	-	Хөгжлийн төвийн тоо	-	1	"Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, асран хамгаалагчдад үйлчлэх төв"-ийг барихаар 2023 оноос санал санаачилгыг гаргаж, зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж нийт төсөвт өртөг 4,5 тэрбум төгрөгөөр Барилга хөгжлийн төвийн магадлалын дүгнэлтээр баталгаажсан.	Хэрэгжээгүй	

							<p>Аймгийн Засаг даргын 2024 оны 01/1181, 01/1719, 2025 оны 01/32, 01/67, 01/288, 01/304, 01/305 дугаар албан бичгээр Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайд “Хүүхдийн төлөө сан”-гийн тэргүүн болон Хүүхдийн төлөө санд нийт төсвийн 50 хувийг тус сангаас санхүүжүүлэх талаар хүсэлтийг удаа дараа хүргүүлсэн боловч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байна.</p> <p>Мөн аймгийн Засаг даргын 2025 оны 01/1700 дугаар албан бичгээр Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарт барилгын нийт төсөвт өртөг болох 4,5 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлэх хамтран ажиллах албан бичгийг хүргүүлсэн.</p>		
<b>3.3.4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар:</b>									
58	3.3. 4.1.	<p>Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг түшиглэн зохион байгуулна.</p>	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Сургалт, мэдээллийн тоо	-	5-аас доошгүй удаа зохион байгуулсан байна.	14	<p>Жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ"-г хэрэгжүүлэхээр аймгийн Жендэрийн салбар хороо 2025 онд 3 зорилт, 18 заалт бүхий төлөвлөгөөг баталж 84.4 хувьтай хэрэгжсэн. Эрүүл идэвхтэй амьдрах тэгш боломж бүрдүүлж, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгах зорилгоор “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд нарийн мэргэжлийн эмч нарын багийг урьж 207 эрэгтэйг үзлэгт хамруулан 100 гаруй өвчлөл илрүүлэн зөвлөгөө өгч, 3 иргэнд шаардлагатай мэс засал хийсэн.</p> <p>Оюутан суралцагчдын дунд нарийн мэргэжлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, 135 оюутан хамрагдсаны 89 нь эрэгтэй байна. Нийт 64 өвчлөл илрүүлж, 86% эрүүлжүүлэв. “Бүх төрлийн тамхины хор хөнөөл”, “Охид хөвгүүдийн эрүүл ахуй”, “Дэлгэцийн донтолт” сэдвийн хүрээнд 4 удаагийн сургалт зохион байгуулж 259 оюутан хамрагдсан.</p> <p>Орон нутгийн түвшинд “Жендэрийн бодлогоор уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах” сэдвээр говь, төвийн болон зүүн бүсийн 10 аймгийн 100 гаруй оролцогчтой сургалтыг зохион байгуулснаар орон нутгийн төрийн байгууллага, төрийн бус байгууллага, малчид, тариаланчдын жендэрийн эрх тэгш байдал ба уур амьсгалын өөрчлөлт хоорондын холбоо хамаарал, жендэрт суурилсан хүчирхийлэл, тулгарч буй саад</p>	Хэрэгжсэн
				Сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо		14			

							<p>бэрхшээл, сайн туршлага, шинэлэг санаачилгын талаарх мэдээллийг солилцсон.</p> <p>Жендэрийн хэвшмэл байдлыг халах, жендэрт суурилсан хүчирхийллийн талаар иргэдийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр "Эмэгтэйчүүдийн оролцоо ба манлайлал", "Жендэр эрх тэгш байдал ба түүний үндсэн ойлголт", "Өсвөр насны хүүхэд рүү чиглэсэн үе тэнгийн дээрэлхэлд, электрон тамхины хэрэглээг бууруулах", "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд" зэрэг 14 удаагийн сургалтыг зохион байгуулж 1,950 гаруй иргэд хамрагдсан нь иргэдийн жендэр, жендэрийн эрх тэгш байдал, салбар дундын хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах талаар мэдлэг ойлголтыг авсан. Өмнөх онтой харьцуулахад сургалтад хамрагдсан иргэдийн тоо 30 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Жилийн эцсийн байдлаар жендэрийн тэгш бус байдлын индекс 0,33 хувь байна.</p>		
<b>3.3.5. Ахмад настны талаар:</b>									
59	3.3.5.1	Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтэд нөлөөллийн ажил зохион байгуулах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Сургалт сурталчилгаа нөлөөллийн ажил 2	-	Иргэдийн ахмад настны тухай хуулийн мэдлэг, мэдээлэл сайжирсан байна.	23	<p>Ахмад настны тухай хуулийг сурталчлан таниулах зорилгоор "Ахмад настны тухай хууль"-ийн шинэчлэлт өөрчлөлт, түүнийг дагалдан гарсан журмуудыг сурталчлах зорилгоор "Ахмадын чуулган"-ыг 9 суманд зохион байгуулж, 4450 ахмад оролцлоо.</p> <p>"Халамжаас-Хөдөлмөрт 222" арга хэмжээг 14 суманд зохион байгуулж, 930 ахмадад "Ахмад настны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт" түүнтэй холбогдон гарсан журмыг сурталчлан таниулах арга хэмжээг хэрэгжүүлснээр иргэдийн ахмад настны тухай хуулийн мэдлэг, ойлголт нэмэгдсэн.</p> <p>Тайлант хугацаанд нийт 23 удаагийн арга хэмжээнд, 5380 ахмадыг хамруулан хуулийн хэрэгжилтийг сурталчлан таниулсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ахмад настны тухай хуулийг сурталчлан таниулах сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан ахмадын тоо 50%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p>	Хэрэгжсэн

60	3.3. 5.2	Ахмадын сан байгуулан ажиллуулах, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ААНБ-тай хамтран ажиллах, хяналт тавих.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо,	Ахмадын сан байгуулсан ААНБ-ын тоо, тэтгэвэр бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлсэн ААНБ-ын тоо	ААНБ-ын 50-аас дээш хувь ахмадын сан байгуулсан байна.	126	Тайлант оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 866 байгууллага байгаагаас ахмадын сан байгуулсан 126 байгууллага, тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр баталж хэрэгжүүлсэн 68 байгууллага байна. Уг хөтөлбөртэй байгууллагуудад 25 удаа танхимаар болон цахим хэлбэрээр сургалт зохион байгуулж, тэтгэвэрт гарах 159 ахмад хамрагдлаа. 2025, 2026 онд тэтгэвэрт гарах ахмадуудын бүртгэлийг сум бүрээс, аймгийн төвийн баг, мэргэжлийн зөвлөлөөр нэгтгэн 159 ахмадыг хамруулсан. Мөн 152 тэтгэвэрт гарах ахмадад мэргэжлийн сургагч багшаар сэтгэл зүйн зөвлөгөө, сургалт мэдээллийг өгсөн.	Хэрэгжсэн
				2.Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлсэн байгууллагын тоо			68		
61	3.3. 5.3	Ахмад настны хөгжил оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, Ахмадын өргөөг ахмад настан бүрт нээлттэй байх талаар анхаарч ажиллах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Баталсан төсвийн хэмжээ /сая төгрөг/	Нийт ахмадын 60 хувь	20-оос доошгүй хувьд хүрсэн байна. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан ахмадын тоо нэмэгдсэн байна.	70,4	Ахмад настны хөгжил оролцоог дэмжих, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэн аймгийн хэмжээнд нийт 1 ордон, 14 өргөө, 25 танхим үйл ажиллагаагаа тогтмол явуулж байгаа бөгөөд урсгал зардал, тоног төхөөрөмжийг тухайн орон нутгийн төсөвт тусгасан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/128 дугаар захирамжаар 70,4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Тайлант хугацаанд 14 салбар хороо 34 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж, 5380 ахмад настан хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан.	Хэрэгжсэн
				2.Үйлчилгээнд хамрагдсан ахмадын тоо			5380		
62	3.3. 5.4	Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих төвийг байгуулж, ахмад настны эрэлт хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжих	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Үйлчилгээнд хамрагдсан тоо	-	Ахмадыг үйлчилгээнд бүрэн хамруулсан байна	5311	Ахмад настны идэвхтэй амьдралыг дэмжих зорилгоор Геронтологийн үндэсний төв болон орон нутгийн Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран ахмад настны эрүүл мэнд, эрүүл насжилт, өвчнөөс урьдчилан сэргийлэх 11 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 2249 ахмад хамрагдсан. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ахмадын хөгжлийг дэмжих "Энэрэл" төв үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгт нийт ахмадуудын 71 хувь буюу 5311 ахмад хамрагдсан бөгөөд ахмадуудын хөшүүн байдлыг арилгах, тэдэнд тохирох хөдөлгөөнт дасгалыг ахмадын хорооны дэргэдэх "Энэрэл" төвийн	Хэрэгжсэн

							<p>ажилтан, ахмадуудаар бичлэг болгон орон нутгийн телевизээр болон пэйж хуудсаар дамжуулан хүргэсэн бөгөөд 3104 иргэний хандалт авсан.</p> <p>Ахмадуудад “Аялгуут дасгал”, “Саваат дасгал”, “Хийн дасгал” зэргийг тогтмол явуулж, бие эрхтний хөшүүн байдлыг арилгах, тогтмол хийж сургах ажлуудыг сум бүрд зохион байгуулж 1159 ахмадыг хамрууллаа.</p> <p>Мөн бүх сумд, мэргэжлийн байгууллагуудын ахмадын зөвлөлийн 45 хувь Шугаман бүжгийн хамтлагтай болж, хөдөлгөөнөөр эрүүлжих болсон.</p> <p>Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/76, 515 тушаалаар Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээг иргэн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр батлагдсан бөгөөд аймгийн ахмадын хороотой 17.5 сая төгрөгийн гэрээ байгуулан 990 ахмад, Замын үүд сумын ахмадын хороотой 8,9 сая төгрөгийн гэрээ байгуулж 500 ахмад, нийт 1490 ахмадад 5 төрлийн үйлчилгээг үзүүлж 26,4 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгохоор хүлээгдэж байна.</p>		
63	3.3. 5.5	Ахмадын настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Цогц үнэлгээнд хамрагдсан ахмад настны тоо	-	Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэл зүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийгдсэн байна.	360	<p>Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээнд хамрагдах ахмад настныг багийн ажлын алба болон өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран цогц үнэлгээг хийж 1, 2 дугаар түвшинд үнэлэгдсэн 360 ахмадыг лавлагаа мэдээллийн үйлчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ, сайн дурын үйлчилгээ, ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээ, зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих 5 үйлчилгээнд хамруулсан.</p>	Хэрэгжсэн

64	3.3. 5.6	Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналт тавих.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан эсэх	-	Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ тогтмолжиж сайжирсан байна.	1	Ахмад настны нийгэм, эрүүл мэндийн цогц үнэлгээ, төрөлжсөн болон хувилбарт үйлчилгээ, асрахуйн болон урт хугацааны тусламж үйлчилгээний кейс менежментийн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр 14 сумын төсөвт байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, эрүүл мэндийн төвүүдтэй хамтран 21 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 257 ахмадыг хамруулсан. , Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/76, 515 тушаалаар Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээг иргэн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр батлагдаж Аймгийн ахмадын хороотой 17.5 сая, Замын үүд сумын ахмадын хороотой 8,9 сая төгрөгийн гэрээ байгуулж, нийт 1490 ахмадад 5 төрлийн үйлчилгээг үзүүлсэн. Дээрх үйлчилгээг өрхийн эмнэлэгтэй хамтран ахмад настанд цогц үнэлгээ хийж 1, 2 дугаар түвшинд үнэлэгдсэн ахмадыг үйлчилгээнд хамруулсан.	Хэрэгжсэн
				2.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо			1		
65	3.3. 5.7	Ахмад настнаа хүндлэх ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагч, оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Бүх шатны боловсролын байгууллагад сургалт хийсэн ахмад настны тоо	-	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна.	7	Ахмад мэргэжилтнүүдийг ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдлэг туршлагыг залуу үед хүргэх зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ”-г 14 байгууллагад хэрэгжүүлж, жилийн эцсийн байдлаар 10 байгууллагын 305 албан хаагчдад 7 ахмад мэргэжилтэн үзүүлж, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлэн ажилласан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлсэн ахмадын тоо ижил түвшинд байна. Төрийн албаны төв байгууллага буюу Төрийн албаны зөвлөлийн үүсгэн байгуулагдсаны түүхт 30 жилийн ойн баярыг тохиолдуулан Монгол Улсын Төрийн албаны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, түүх бүтээлцэн, удирдлага манлайлалтай ажиллаж байсан 4 ахмад төрийн албан хаагч, одоо ажиллаж байгаа нийт 40 гаруй төрийн албан хаагч нарын “Ахмадаа сонсьё” дурсамж уулзалтыг зохион байгуулсан. Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллагуудын 3 үеийн уулзалтыг зохион нийт 150 гаруй 3 үеийн төлөөллийг хамрагдсан.	Хэрэгжсэн
				2.Ажиллаж байсан байгууллага даа сургалт хийсэн ахмад настны тоо			7		

							Гэр бүлийн гишүүдийн ёс зүй, үүрэг хариуцлага үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ахмадын хороотой хамтран 25-аас дээш жил амьдарсан 11 ахмад гэр бүлийг алдаршуулах алтан хуримын ёслолын "Ханьсахын жаргал" арга хэмжээ, ахмадын "Нумт" шагайн клубтэй хамтран 35 гэр бүлийн шагайн харвааны "Аргайн хосууд" арга хэмжээг тус тус зохион байгуулж, 2,6 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Мөн "Угийн бичиг удмын хэлхээ" сургалтыг Сайншанд сумын 120 ахмадыг хамруулан зохион байгуулж, 3,8 сая төгрөгийг шийдвэрлэсэн бөгөөд сургалтын үр дүнд угийн бичгийн уламжлалыг хадгалах, хойч үедээ өвлүүлэх соёлыг төлөвшүүллээ.		
66	3.3. 5.8	Ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэх.		1.Журам баталсан эсэх 2.Оршуулах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ	-	Журмыг ИТХ-аар батлуулсан байна. Ганц бие орон гэргүй ахмад настанд үзүүлэх үйлчилгээ сайжирсан байна.	-  30,0 сая төгрөг	Тайлант онд говийн бүсийн төрөлжсөн асрамжийн газар асруулж буй 2 ахмад, нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүсээгүй 3 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 10 иргэний оршуулгын зардалд нийт 30,0 сая төгрөг зарцуулсан.	Хэрэгжээг үй
67	3.3. 5.9	Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан "Өмчийн төрөл хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуй нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна" гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах, хяналт тавих.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	50-аас дээш ажилтантай аж ахуй нэгж байгууллагад хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо  Үүнээс ажиллаж байгаа ахмад настны тоо	Суурь түвшний тоо	Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилт хангагдаж ахмадуудын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	395  758 ахмад	Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 50 буюу түүнээс дээш ажилтантай 70 аж ахуйн нэгж байгууллагат 395 ахмад ажиллаж байгаа бөгөөд 50 буюу түүнээс доош ажилтантай 196 байгууллагат 363 ахмад настан, нийт 266 аж ахуйн нэгж байгууллагат 758 ахмад настан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийгмийн даатгалын шимтгэл төлж хөдөлмөр эрхэлж байгаа 758 ахмад, нэмэлт орлого олж байгаа 453 нийт 1210 ахмад байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 32.1 хувиар нэмэгдсэн байна.	Хэрэгжсэн

68	3.3. 5.10	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах.	Орон нутгийн төстийн хөрөнгөөр	1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо	-	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилт хангагдсан байна.	3  289,4 сая	<p>Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын 2025 оны А/51 дугаартай захирамжаар "Жаргалан" хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны зардалд 45.0 сая төгрөг, А/52 дугаартай захирамжаар аймгийн Түр хамгаалах байрны үйл ажиллагааны зардалд 140.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.</p> <p>"Жаргалан" хүүхдийн зусланд 4 ээлжээр 700 хүүхдийг хүлээн авч хөгжлийн үйлчилгээнд хамруулсан бөгөөд харуулын цалин, цахилгааны төлбөрийн тооцоо, зуслангийн үйл ажиллагаа эхэлж байгаатай холбогдуулан гэрэлтүүлэг, засвар үйлчилгээтэй холбоотой нийт 44,1 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Түр хамгаалах байр 2 нийгмийн ажилтан, 1 сэтгэл зүйчийн орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж, 35 хүүхэд, 1 иргэнийг 4-31 хүртэлх хоногоор хүлээн авч эрүүл мэнд, боловсрол, ахуйн болон нөхөн сэргээх үйлчилгээг 100% үзүүлсэн. Түр хамгаалах байрны ажилчдын цалин, хоол хүнс, шаардлагатай материал, харуул хамгаалалтын үйлчилгээний төлбөрт 64,4 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Мөн аймгийн Ахмадын хорооны үйл ажиллагааны зардалд 70,4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.</p> <p>"Дэлгэр говийн хүн сан" ТББ-ын санаачлан хэрэгжүүлсэн "0 эрсдэлгүй орчин" төслийн дагуу 1.0 сая төгрөгийн дэмжлэгээр аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан ээлтэй гудамж бүрдүүлэх зорилгоор Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн авто замын 2 байршилд "Сургууль орчмын бүс" босоо тэмдгийг засварлаж, сайжруулан анхааруулах анивчдаг гэрэлт тоноглолыг суурилуулсан.</p> <p>Мөн Сайхандулаан суманд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан явган замыг нийгмийн хариуцлагын хүрээнд 33.0 сая төгрөгийн</p>	Хэрэгжсэн
----	--------------	---	--------------------------------	--	---	---	--------------------	--	-----------

								хөрөнгө оруулалтаар "Говь Вентур" ХХК хийж гүйцэтгэсэн.	
Нийт дундаж дүн									95,0%

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА



О.БАТЖАРГАЛ

ТАЙЛАН ХЯНАСАН:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.МӨНХЦЭЦЭГ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
ХҮН АМ ЗҮЙ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГО  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.ЭНХТӨВШИН